



Saiga Conservation Alliance

Бөхөнгийн Мэдээ

2007 зуны дугаар 5

Бөхөнгийн хамгаалал, экологийн талаар мэдээлэл санаа солилцох 6 хэл дээр гарч буй хэвлэл

Агуулга

Сэдэвт өгүүлэл – хуудас 1

Е.Ж.Милнер Гулланд. Бөхөн хамгаалах холбоо

Шинэ мэдээ – хуудас 2-4

- Бөхөн гөрөөсийг гаршуулан үржүүлэх олон улсын хамтын ажиллагааны хэтийн төлөв
- Халимагийн докторант Сидней Баерсийн Итгэлийн Сан (Sidney Byers Trust)-гаас тэтгэлэг авлаа
- Гансу Вүвэйн Зэрлэг Амьтан Үржүүлэг, Судалгааны Төв дэх бөхөнгийн шинэ үе
- "Бөхөнгийн амьдрал" номын хуудсыг сөхөхүй
- Устюртын хүүхдүүд бөхөн зурлаа
- "Возрожденный" арлын бөхөн
- Приморский мужид олон тооны бөхөнгийн эвэр хураагдав
- Халимагт бөхөн хулгайгаар агнасан хүмүүсийг шоронд хорив
- Бөхөнгийн эвэр хууль бусаар худалдаалахыг оролдсон Хятадын иргэнийг Казахстангаас гаргалаа
- Тайваны цагдаа хар зах дээр худалдаалагдаж байсан бөхөнгийн эврийг хураан авлаа

Бөхөнгийн тухай - Хуудас 4

Людмила Сарангова, "Бөхөн буцаж ирсэн нь", Известия Калмыкии, 2007 оны 5 сарын 26

Өгүүлүүд – хуудас 5-9

- Е.Ж.Милнер-Гулланд, ИНТАС төсөл амжилтанд хүрэхэд ойрхон байна
- Ю.А.Грачев, А.Б.Бекенов, Устюрт дахь бөхөнгийн нөхөн үржихүй
- М. В.Холодова. Бөхөнгийн филогеографи
- А.В.Хлуднёв, Астраханий "Степной" агнуурын нөөц газар бөхөн хамгааллын байдал
- С.Айверсон, Бөхөнгийн нутгаар аялсан мартагдашгүй дурсамж

Төслийн эргэн тойронд –10 хуудас

Бөхөн хамгаалахад Узбекистаны нутгийн оршин суугчдын оролцоо

Бөхөн хамгаалах холбоо Бөхөн хамгаалах тухай санамж бичгийн (БХСБ) биелэлтийг хянаж байна - Хуудас 10-11
2006 оны 9 сараас 2007 оны 6 сар хүртэлх хугацаанд БХСБ-ийн дагуу хийсэн ажлын явцын тайлан

Бөхөнгийн талаарх хэвлэлийн тойм - Хуудас 11-12

Бөхөн хамгаалах холбоо (БХХ)

БХХ нь хурдацтай өргөжин хөгжиж байна. Холбооны Удирдах зөвлөл дүрмээ баталж өөрсдийн шинэ веб хуудас болон банкинд данстай боллоо. Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар бидний веб сайтанд зочилно уу!
www.saiga-conservation.com

Бөхөн хамгаалах үүрэг амлалт, бөхөнгийн газар зүйн тархалт

Бид "Бөхөнгийн мэдээ" сэтгүүлийн редакцийн зөвлөлийн гишүүдтэй БХХ-ны Удирдах Зөвлөл анхны уулзалтаа хийхээр товллоо. Удирдах зөвлөлийн уулзалт Ташкент хотноо энэ оны 9 сард болох ба уулзалтаар БХХ-ны стратеги төлөвлөгөөг хэлэлцэж, мөн БХХ-ны салбарыг олон улсын болон орон нутгийн түвшинд байгуулах боломжийг хайна. Одоогийн байдлаар бид шинээр гишүүн элсүүлэх ажлыг эхлүүлэхээр зэхэж байна. "Бөхөнгийн мэдээ" сэтгүүлийг дэмжигчидийг бид БХХ-г үндэслэгч гишүүн болон нэгдэхийг урьж байна. Бидэнтэй нэгдэхийн тулд энэхүү урилгыг хүлээн авч буйгаа дурдсан товч захиаг БХХ-ны нарийн бичгийн дарга Елена Быкова (esip@tkt.uz) -д и-мэйл болон шуудангаар илгээхэд хангалттай. Гишүүнээр элсэхэд үнэгүй хэдий ч таны хандивыг талархалтайгаар хүлээн авч БХХ-ны үйл ажиллагаанд зарцуулах болно. Та гишүүн болохын тулд БХХ-ны үүрэг, зорилгыг дагаж мөрдөх үүрэг хүлээнэ.



Бөхөнгийн нялх янзгаа.
Зургийг И.Ж.Милнер-Гулланд

Бид бөхөнг Төв Ази болон Каспий орчмын шүхэр зүйл хэмээх байранд буцаан аваачиж, соёл, эдийн засгийн үнэ цэнийг нутгийн иргэдэд таниулан, тал хээрийн экосистемийн үндсэн үүргийг сэргээх тал дээр ажиллана. Бид хамтран ажиллаж бөхөнгийн талаарх өөрсдийн туршлага, сонирхлыг чөлөөтэй хуваалцана. Бид өөрсдийн бөхөн хамгааллын ажлыг дэлхий нийтэд болон засгийн газрууд, бусад байгаль хамгаалах томоохон байгууллагуудад өргөн хүрээтэй сурталчилна.

Гишүүн нь хувь хүн болон албан байгууллага байж болно. Хэрэв та гишүүнээр элсвэл бид таны гишүүний жагсаалтанд талархалтайгаар бүртгэн, мэдээллийн сүлжээгээр хангана. Гишүүнээр элссэн та бүхнийг бид өөрсдийн БХХ-тай холбоотой хамгааллын үйл ажиллагаанд нэгдэнэ гэдэгт найдаж байна. Бөхөн хамгаалалтай холбоотой төслүүд нь БХХ -ны логог ашиглаж болох бөгөөд мөн өөрсдийн сурталчилгааг интернетиийн хуудсанд үнэгүй байршуулан, "Бөхөнгийн мэдээ" сэтгүүлийн аль ч хэсэгт нийтлэх боломжтой.



БХХ-ны багийнхан Устюрт дахь бөхөнгийн янзгаануудад судалгаа хийж байгаа нь.
Зургийг Жин-Франсуа Лагрот



БХХ-ны урианд тангараг өргөсөн хүүхдүүд тэмдгээ зүүцээд байгаа нь. Элиста дахь хүүхдийн төв "Аршан"-д.
Зургийг И.Ж.Милнер-Гулланд

Бид санхүүжилт олох эх үүсвэрийг эрж хайх ба бөхөн хамгаалалтай холбоотой жижиг төслүүдийн уралдааныг зарлах болно. Та бүхэн гишүүдийн үүрэг, хариуцлага, мөрдөх дүрэм, БХХ-ын удирдлагын бүтэц зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг манай веб хуудаснаас авч болох ба хэрэв хүсвэл хэвлэсэн хувилбарыг Удирдах Зөвлөлийн аль ч гишүүнээс хүлээн авч болно.

БХХ нь зөвхөн гишүүдийн дэмжлэгтэйгээр амжилтанд хүрэх билээ. Та бүхэн бидний урилгыг хүлээн авч бидэнтэй нэгдэн бөхөн хамгаалах хүчирхэг санг хамтдаа бий болгоно хэмээн найдаж байна.

Е.Ж.Милнер Гулланд (Бөхөн хамгаалах холбооны тэргүүн),
e.j.milner-gulland@imperial.ac.uk

Редакцийн зөвлөл. Хятад: Доктор А.Канг, WCS-ын Хятад дахь салбар (ygling@online.sh.cn); Казахстан: Профессор А.Бекенов, доктор Лу.А.Грачев, Амьтан судлалын хүрээлэн (terio@nursat.kz); Монгол: доктор Б.Лхагвасүрэн, Доктор Л.Амгалан, Биологийн хүрээлэн (ecolab@maginet.mn), . Онон, WWF Mongolia, (onon@wwf.mn); Орос: Профессор Ю.Арылов, Халимаг улсын Зэрлэг амьтны төв, доктор А.А.Луцкеина, Эволюци ба экологийн хүрээлэн (mab.ru@relcom.ru); Туркменстан: Доктор Д.Сапармуратов, Цөлийн амьтан, ургамлын хүрээлэн (desert@online.tm; saparmuradov@mail.ru); Узбекистан: Доктор Е.Быкова, доктор А.Есипов, Амьтан судлалын хүрээлэн (esip@tkt.uz); Нэгдсэн вант улс: Доктор Е.Ж.Милнер-Гулланд, Лондоны эзэн хааны колледж (e.j.milner-gulland@imperial.ac.uk).

Сэтгүүлийг санхүүжүүлсэн:



with additional support from:



Хэвлэгдсэн нийтлэлүүдийг <http://saigak.biodiversity.ru/publication.html> юмуу www.iccs.org.uk/saiganews.html хаягуудаар нэвтрэн орж pdf файл хэлбэрээр авах ба хэвлэлийн эхийн хуулбарыг Англи, Орос, Хятад, Монгол, Казах, Узбек хэл дээр авч болно.

Бөхөнгийн талаарх мэдээ, материалыг 6 хэл дээр хүлээн авна. Мэдээ, материалуудаа esip@tkt.uz хаягаар илгээх эсвэл редакцийн зөвлөлийн гишүүдийн хаягаар хандаж болно. Бид жилд хоёр дугаар гаргана.

Шинэ мэдээ

ОЛОН УЛС БОЛОН ОРОН НУТАГТ

Бөхөнг гаршуулан үржүүлэх олон улсын хамтын ажиллагааны хэтийн төлөв

Халимагийн Зэрлэг Амьтны Төв (ХЗАТ)-ийн захирал Юрий Арылов болон Оросын ШУА-ын Эволюци Экологийн Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан Анна Луцкекина нар 2006 оны сүүлчээр АНУ-ын Зэрлэг Амьтан Хамгаалах Төвийн Консервациумаас зохион байгуулсан аялалд 2 долоо хоног оролцлоо.

Уг аялал нь бөхөн хамгаалалд нэгдэх хүсэлтэй Америк судлаачдын хүсэлтээр зохион байгуулагдсан ба тэд ХЗАТ-ийн бөхөн амжилттай гаршуулан үржүүлсэн 7 жилийн туршлагыг сонирхож байна. Биднийг урьсан хүмүүс судалгааны төвийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын (янзага тэжээн асрах, физиологийн статусыг судлах аюул багатай арга зүй, бөхөнгийн үрийн шингэнг хадгалах, байгалийн бэлчээрийг нөхөн сэргээх туршилтын ажлууд гэх мэт) үр дүнг сонирхсон. Зочдод Калифорни дахь Сан Диего Зоо Парк, Флорида дахь Зэрлэг амьтадын хүрээлэн, Цагаан царсны төв, Охайо дахь Зэрлэг амьтадын төв, мөн Смитсоныан Хүрээлэнгийн харъяа Үндэсний Амьтны Хүрээлэнгийн Эрдэм Шинжилгээний Судалгааны Төв дэх амьтны аж ахуйн үйл ажиллагааг үзэж сонирхох алтан боломж олдсон юм. Бөхөнг зохиомлоор хээлтүүлэх, улмаар үр хөврөлийг шилжүүлэн суулгах хэтийн судалгааг хамтран явуулах тал дээр зөвшилцөлд хүрэв. Эдгээр техникийн ажлыг ОХУ-ын Петербургийн Генетикийн Хүрээлэн болон Москвагийн Амьтны Аж Ахуйн хүрээлэн гэрийн амьтдад хэрэглэж байсан туршлага байна. Бид Халимагийн Их Сургуулийн багш, оюутнуудыг энэхүү төсөлд татан оролцуулахаар төлөвлөж байна. Судалгааны цэгүүдийн нэг бол Халимаг Улсын Их Сургуулийн ХАА-н факультетын бичил ферм юм. Америкийн мэргэжил нэгт нөхөд маань мөхөж буй талын гөрөөсийг хамгаалж буй бидний хэсэг эрдэмтдийн судалгааны ажилд хувь нэмэр оруулах болсонд гүнээ талархаж байна. Тэд бөхөн хамгаалах бидний ажилд туслахад бэлэн байгаа бөгөөд Зэрлэг Амьтны Төвийнхөнд хүчтэй нөлөө бүхий anthelmintic, антибиотик, амьтан унтуулах буу зэргийг бэлэглэлээ. Америкийн мэргэжилтнүүд манай улсад 2007 оны намар айлчлан ирнэ гэдэгт бид найдаж байгаа. Тэдний айлчлалын үеэр бөхөн болон байгаль хамгаалахтай холбогдсон дугуй ширээний уулзалтыг зохион байгуулж, оюутнууд болон сургуулийн хүүхдүүдтэй хийх уулзалт, кино, хурал, болон бусад арга хэмжээнүүдийг зохион байгуулна.

Иван Минков, “Халимагийн Зэрлэг Амьтны Төв”-ийн төв хэлтэс.



Зүүн гар талын зурган дээр Ю.Арылов болон түүний хамтран зүтгэгчид Виржини дахь Үндэсний Зоо Паркийн Судалгааны төвд. Баруун гар талын зурган дээр Ю.Арылов Вайтэр Оак төвд анааш тэжээж байгаа нь. Зургийг Анна Луцкекина



Хойд Америкийн байгаль хамгаалах 5 байгууллага хамтран Conservation Centers for Species Survival (CCSS) хэмээх консорциумд нэгдэн орлоо. Калифорны Сан Диего дахь Эскондидо хэмээх хот дахь Зоо Парк, Техасын Глэн Розын Зэрлэг амьтан хамгаалах Фозил Рим Төв, Охайогийн Вайлдс оф Кумберланд, Флорида дахь Юлийгийн Цагаан царсны төв, Виржиниагийн Смитсоныан Хүрээлэнгийн харъяа Үндэсний Амьтны Хүрээлэнгийн Эрдэм Шинжилгээний Судалгааны Төв зэрэг байгууллагууд бүгдээрээ нэн ховор зүйлийг нөхөн сэргээх менежментын асуудал, тэдгээрийг гаршуулан үржүүлэх, эрдэм шинжилгээний судалгаа зэрэгт ихээхэн туршлагатай. Уг консорциум нь аюул занал учирсан зүйлүүд эсэн мэнд үлдэхэд шаардагдах онцгой хэрэгцээ, нөөц бололцоог хамтран хангадаг. CCSS-аас амьтдын нөөц, түүнээс ашиг олох боломжтой нэн тэргүүний амьтдын зүйлийн тоог гаргасан. Бөхөн бол эдгээр зүйлүүдийн нэг юм. CCSS-ийн хүрээлэнгүүд нь өөрийн мэдлэг чадварыг Халимаг дахь бөхөн үржүүлэх хөтөлбөрт зориулахыг туйлын ихээр сонирхож байна. Уг бүлэг нь одоогийн байдлаар Судалгааны төвд зохион байгуулах богино хэмжээний сургалтын хөтөлбөрийг боловсруулж байгаа ба ирээдүйд хамтран ажиллах бусад боломжуудыг хайж олно гэдэгт найдаж байна.

Дан Беетем, The Wilds (djbeetem@yahoo.com)

Халимагийн докторант Сидней Баерсийн Итгэлийн Сан (Sidney Byers Trust)-гаас тэтгэлэг авлаа



2007 оны 4 сарын 6 нд Зэрлэг Амьтныг Хамгаалах Сүлжээ (ЗАХС) нь Sidney Byers Trust тэтгэлэгт хөтөлбөрийн ялагчдыг зарласан бөгөөд энэ нь нэн ховор зүйлүүдийг хамгаалахын төлөө ажиллаж буй Африк, Ази, Зүүн Европ болон Өмнөд Америкийн залуу судлаачдад зориулагдсан. Уг хөтөлбөрт нэр дэвшигчдийг ЗАХС-ийн хамтран ажилладаг байгууллагуудаас гаргадаг. Надежда Арылова БХХ-ноос нэр дэвшсэн бөгөөд 7 ялагчийн нэг болж чадсан юм. Тэрээр Халимагийн бөхөнгийн нөхөн үржихүйн судалгааг хийдэг бөгөөд Оросын ШУА-ын Экологи ба Эволюцийн хүрээлэнд ажилладаг. Бид Надеждаг тэтгэлэг авсанд нь баяр хүргэж байгаадаа таатай байна.

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл доорх хаягаар хандана уу! <http://www.iccs.org.uk/papers/ScholarshipWinnersPressRelease2007.pdf>

Гансу Вүвэйн Зэрлэг Амьтан Үржүүлэг, Судалгааны Төв дэх бөхөгийн шинэ үе

2007 оны 5 сард Гансу Вүвэйн Зэрлэг Амьтан Үржүүлэг, Судалгааны Төвд бөхөгийн шинэ удам мэндэлж 4 эм, 7 эр янзагатай боллоо. Уг судалгааны төв дэх бөхөгийн нийт тоо одоогийн байдлаар 50-д дөхөж байгаа нь сүүлийн 20 жил дэх хамгийн дээд хэмжээ юм. Гэсэн хэдий ч судалгааны төв бөхөгийн хүйсийн харьцаанд сэтгэл зовж байна. Нийт бие гүйцсэн амьтдын 60% нь эр, шинээр төрж буй янзагануудын 63% нь мөн эр байна. Бөхөгийн ооно хоорондоо тулалдах, бие биенийгээ хөөх үедээ эврээрээ бусдыгаа гэмтээх, тэр ч бүү хэл шаргагчинг хөнөөсөн хэд хэдэн тохиолдлууд бүртгэгдээд байгаа билээ. Сүүлийн хэдэн жилд ооно шаргагчингийн харьцаа эрс ялгаатай байгаа энэхүү сонирхолтой зүйлийг тэмдэглэх нь зүйтэй. Судалгааны төвийнхөн бөхөгийн ооны зарим хэсгийг тусгаарлахын тулд нэмэлт хашаа барихаар төлөвлөж байна. Ингэснээр шаргагчин гэмтэх явдал багасгах юм. Гэвч судалгааны төвийнхөнд амьтдыг хэрхэн эрсдэл багатай тусгаарлах тал дээр туршлага алга. Хэрэв энэ тал дээр санал, зөвлөмж, мөн хэрэгтэй мэдээлэл байвал судалгааны төвийнхөн таатайгаар хүлээн авах болно.

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл Али Кангтай холбоо барина уу! ygling@online.sh.ch

“Бөхөгийн амьдрал” номын хуудсыг сөхөхүй

Известия Калмикии, 2007 оны 3 сарын 21

Халимагийн зэрлэг амьтны төвөөс “Бидний амьд өв болсон бөхөнг хамгаалъя”, “Миний тухай бүхнийг мэдэх үү?” гэсэн гарчигтай товхимолыг хэвлэн гаргалаа. Энэхүү анхны товхимол нь уг ховор амьтны амьдралын талаар шинэ соргог зүйл, хамгааллын арга хэмжээнүүд, бөхөгийн популяцид хүний зүгээс үзүүлж буй нөлөө, мөн бөхөн хамгаалах CWA Сан хэрхэн байгуулагдсан зэрэг мэдээллийг багтаажээ. Эдгээр хэвлэлүүд нь хэдэн зууны турш өргөн уудам агьт талын уугуул болсон бөхөнг олон түмэнд дэлгэн таниулж байна. Нэмж хэлэхэд Халимаг дахь бөхөн хамгаалалд зориулсан “Үхэр үржүүлэг ба тугал” хэмээх төслийн талаарх зурагт хуудасыг DEFRA-аас санхүүжүүлж буй SEPS төслийн хүрээнд хэвлэн гаргалаа.

Устюртын хүүхдүүд бөхөн зурлаа

Каракалпакистан (Узбекистан)-ы алслагдсан хоёр тосгоны сургуулийн хүүхдүүдийн дунд бөхөн хамгаалал сэдэвт зургийн уралдааныг 2007 оны 4-5 сард зохион явууллаа. Бөхөн Хамгаалах Холбооноос уг уралдааныг санаачилсан бөгөөд WCN санхүүгийн дэмжлэг үзүүлсэн юм.

Уралдаан нь Каракалпакиа, Жаслик, Кунград дүүргүүдийн тосгонуудад орших 3 сургуулийн дунд уран зураг болон хатгамал гэсэн хоёр төрлөөр явагдлаа. Хүүхдүүд, багш нар өвөрмөц болон чадварлаг гар урлал хийн тэмцээнд урам зоригтой оролцсон. Хамгийн сонирхолтой бүтээлүүдийг АНУ-ын Калифорни мужид WCN-аас жил бүр зохион явуулдаг Зэрлэг Амьтан Хамгааллын Үзэсгэлэн Яармагт дэлгэн үзүүлнэ. Дараа нь багш нар, сургуулийн хүүхдүүдтэй хамтран бөхөгийн тухай тусгайлан хичээл хийлээ. Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл Елена Быковатай холбоо барина уу! esip@tkt.uz



Зүүн гар талын зурган дээр Каракалпакиа тосгоны 26-р дунд сургууль дээр зохиогдсон бөхөгийн сэдэвт гар зургийн уралдааныг дүгнэж байгаа нь. Баруун гар талын зурган дээр Каракалпакиа тосгоны 26-р дунд сургууль дээр зохиогдсон бөхөгийн сэдэвт гар урлалын уралдаанд түрүүлсэн хүүхдүүдэд шагнал гардуулж байгаа нь. Зургийг Елена Быкова, Александр Есипов нар

“Возрожденный” арлын бөхөн

Оросын газрын тос, байгалийн хий олборлодог Люкойл компани болон Узбекистан улсын Байгаль хамгаалах холбоо “Госбиоконтрол” хамтран 2007 оны 5 сард Арал тэнгис (Узбекистан) -д орших хуучин арал байсан “Возрожденный” (одоогоор хойг) орчмын судалгааг хийж гүйцэтгэв. “Возрожденный” арал нь хуучнаар ЗХУ-ын үед хаалттай газар нутаг байсан бөгөөд бөхөн байдгийг судлаачид мэддэг байсан боловч уг арлын биологийн олон янз байдлыг бага судалсан байжээ. Уг хойгт 50 орчим тоотой бие гүйцсэн бөхөгийн тусгаар сүрэг тэмдэглэгдсэн байна. Харин янзага ажиглагдсангүй. Байгалийн жамаар үхсэн бөхөгийн хэд хэдэн сэг тааралджээ. Өнөө үед уг газар нутагт хүний нөлөө бага учраас эндхийн бөхөгийн сүрэг хулгайн ангийн дарамтанд өртөөгүй байна. Иймээс энэхүү бөхөгийн сүргийн нарийвчилсан судалгааг хийх шаардлагатай байгаа юм.

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл Артур Нурижановтай холбоо барина уу! nuridjanov@mail.ru . esip@tkt.uz

Приморский мужид олон тооны бөхөгийн эвэр хураагдав

Хоролский дүүргийн Дотоод явдлын хэлтсийн эргүүлийн ажилчид 2007 оны 1 сарын 18 нд ачааны машинд ачсан барын арьс 3, баавгайн савар 283, бөхөгийн эвэр 581, мөн хүүдийд боолттой барын яс болон хөл тус илрүүлэн хурааж улсын орлого болгожээ. Амьтны ийм их хэмжээний эд эрхтэн сүүлийн 10 жилд Оросын Алс Дорнодод хураагдаж байгаагүй хэмээн Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гаас мэдэгдлээ. Уг гэмт үйлдлийн шийтгэлд шоронд хорих ял төлөвлөж байгаа гэнэ.

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл доорх хаягаар хандана уу!

http://www.wwf.de/presse/details/news/grausiger_fund/39/cHasch/c22385d79f/ болон

http://subscribe.ru/archive/home_pets.bcatsproject/200701/18171703.html

Халимагт бөхөн хулгайгаар агнасан хүмүүсийг шоронд хорив

Халимагийн Яашкул дүүргийн шүүх 2007 оны 3 сард бөхөн хулгайгаар агнасан Халимагийн Яашкул дүүргийн 2 иргэнийг шийтгэв. Халимаг улсаас уг хулгайн ангийн хохирлын хэмжээг 48000 рубль (1700 \$)-р үнэлсэн байна. Хулгайн анчдад хоёуланд нь нэг жил 6 сарын хорих ял болон 1 жилийн тэнсэн ял оноожээ.

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл доорх хаягаар хандана уу! <http://www.regnurn.ru/news/8039111.html>

Бөхөнгийн эвэр хууль бусаар худалдаалахыг оролдсон Хятадын иргэнийг Казахстанас гаргалаа

Казахстаны Караганда хотод Хятадын нэг иргэн 200 орчим кг бөхөнгийн эвэр худалдаалахыг завдсан талаар ИНТЕРФАКС агентлаг мэдээллээ. Хятад иргэний уг гэмт үйлдэлд торгууль ноогдуулан Казахстанас хөөн гаргасан байна. Казахстаны Бүс нутгийн ойн аж ахуй болон ан агнуурыг зохицуулах газраас мэдэгдэж байгаагаар уг хууль бус наймаачин Карагандад жуулчны визтэй ирсэн ба үл таних хүнээс бөхөнгийн эвэр худалдан авч хөлсний байранд хадгалж байжээ. Казахстаны хуулиар бөхөн агнах болон эвэр худалдаалахыг завдсан хүнийг эрүүгийн болон иргэний хуулиар шийтгэдэг аж.

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл доорх хаягаар хандана уу! http://www.interfax.ru/r/B/politics/2.html?id_issue=11656506.



Хятадын уламжлалт эмийн дэлгүүрт зарагдаж буй бөхөнгийн эвэр. Зургийг Матиас Россбах

Тайваны цагдаа хар зах дээр худалдаалагдаж байсан бөхөнгийн эвэрийг хураан авлаа

Тайваны байгаль орчны мэдээллийн төв, 2007 оны 5 сарын 1

Саяхан Тайваны цагдаа болон гаалийн ажилтнууд 100 орчим кг 680 ширхэг бөхөнгийн эвэрийг хурааж авсан бөгөөд эдгээр нь хар захын ханшаар 5 сая RMB буюу 650.000 орчим ам.доллар юм. Нэгж үнэ нь 50-75 мянган RMB буюу 6500-9000 ам.доллар хүрдэг. Уг хяналт шалгалт нь Тайван дахь Хятадын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн үйл ажиллагааны төлөвлөгөөний нэг хэсэг юм. Энэхүү шалгалтын хүрээнд хөдөө аж ахуй, загас, мал, амьтны гаралтай бүтээгдэхүүн болон дарсны хууль бус худалдааг таслан зогсоох алхмуудыг хийсэн. Гаалийн болон цагдаагийн ажилтнууд эдгээр бөхөнгийн эвэрийг энгийн эргүүлийн үед илрүүлжээ. Эдгээр эврүүдийг Азийн Зэрлэг Амьтныг Хамгаалах холбоо болон Мушаны Амьтны Хүрээлэн рүү илгээж эдгээр эврүүд нь африкийн гөрөөснүүдийн эврээс өөр болохыг тогтоожээ. Уг холбоо эдгээр эврүүд бөхөнгийнх болохыг тогтоосон байна.

Бөхөнгийн тухай мэдээ

Орос: Известия Калмики (Халимагийн мэдээ). 2007 оны 5 сарын 26

Бөхөн буцаж ирсэн нь

Дэлхийн нийтийн анхаарал бөхөн рүү чиглэж байгаа энэ үед хэлэлцэх асуудал бишгүй их байна. Энэхүү хосгүй амьтан нийт тархац нутгийнхаа хэмжээнд устахын ирмэг дээр өнөөг хүртэл байсаар байна. Гэсэн хэдий ч бөхөнгийн хамгаалал жилээс жилд сайжирч байгаа билээ. Сүүлийн жилүүдэд бөхөнгийн популяцид өсөх хандлага ажиглагдсан байна. “Чёрные Земли” Байгалийн нөөц газрын орлогч дарга Борис Убушаев энэ талаар Известия Калмики сонинд ярилцлага өгчээ.

Өвөл дулаан байсан учраас бөхөнгийн төллөлт ердийнхөөс эрт буюу 4 сарын 28-нд эхэлж 5-р сарын 9 гэхэд аль хэдийн дуусчээ. Урьдчилсан судалгаагаар 14000 орчим шаргагчин янзагалсан мэдээ байна. Биднээс 2 км зайд “Тенгутинский” улсын нөөц газарт гэхэд 500 орчим шаргагчин янзагалсан. Өмнөх жилүүдэд бид зөвхөн 7000-9000 янзага тэмдэглэсэн. Эндээс үзэхэд сүүлийн жилүүдэд популяцийн хэмжээ өсөж тоо толгой тогтворжиж байгаа нь харагдаж байна. Энэ нь Оросын бөхөн хамгаалахад чиглэсэн олон байгууллагуудын хамтарсан үйл ажиллагааны үр дүн юм. Бид нар Британийн засгийн газрын “Дарвины санаачлага” хөтөлбөрөөр нэгдсэн. Энэхүү Халимагийн бөхөн хамгаалах олон улсын төсөл нь 2003 онд эхэлсэн бөгөөд төслийн зохицуулагчаар Лондоны Эзэн Хааны Коллежийн доктор Е.Ж.Милнер Гулланд ажилласан. Чёрные Земли Байгалийн Нөөц Газар, Халимагийн Зэрлэг Амьтдын Байгалийн Нөөцийн Зөвлөл, Халимагийн Россельхознадзор Хэлтэс (Оросын ХАА-н Хяналт), Зэрлэг Амьтны Төв, Оросын ШУА-ын Хүмүүнлэгийн Судалгааны Калмик Хүрээлэн, Даарма Төв, Яашкулын Дунд сургууль, болон Элиста Хүүрдийн Төв зэрэг байгууллагууд Халимаг дахь энэхүү төслийг хэрэгжүүлэхэд хамтран ажилласан.

Бөхөнгийн тоо толгойд байгалийн хүчин зүйл болох цаг агаар, зэрлэг амьтад нөлөөлдөг хэдий ч бууралтанд нөлөөлөх үндсэн шалтгаан нь хулгайн ан учраас орон нутгийн иргэдийг анхаарч үзэх нь төслийн хэрэгжилтэнд чухал юм. Энэхүү төслийн өөр нэг хэсэг бол Яашкул, Комсомольск дүүргийн дээд сургуулийн оюутнууд өөрсдийн дүүргийн нутагт амьдарч буй оршин суугчдын дунд амьжиргааны түвшин, бөхөнд учирч буй аюул заналд тэдний зүгээс хандах хандлага, бөхөн хамгааллыг хэрхэн сайжруулах талаарх санал зэргийг багтаасан социологийн судалгааг явуулсан. Судалгааны үр дүнд хулгайн агналтыг зогсоохын тулд байгалийн нөөц газрын чадавхийг сайжруулах, иргэдийн амьжиргааг дээшлүүлэхийн тулд нутгийн иргэдэд туслах гэсэн ажиллах хоёр чиг гарч ирсэн билээ. “Дарвины санаачлага” төслийн төлөөлөгчид Халимагт 9 өдөр айлчилсан бөгөөд төслийн зохицуулагч Е.Ж.Милнер Гулландыг бөхөнгийн өнөөгийн байдалд сэтгэл зовинож явдаг хүмүүс дагалдан явсан юм. Энэхүү айлчлалын үед хүн бүр өөрийн тусгай үүрэгтэй явсан. Нэг хэсэг нь зохион байгуулалтын асуудлыг шийдэж байхад, нөгөө хэсэг нь өөрсдөө байгальтай танилцаж байсан. Гэсэн хэдий ч хүн бүр Элиста, Комсомольск, болон Яашкул дүүргийн сургуулийн хүүхдүүдтэй ярилцаж байв. Зочид эдгээр сургуулийн хүүхдүүд бөхөнд учирч буй бэрхшээлд хэрхэн сонирхсоор ирсэн. Аль хэдийн олон хандаж байгааг хараад сэтгэл хангалуун байсан юм. Роза Байк баримтат кино хийж, үүндээ зөвхөн бөхөнд учирч буй аюул заналын талаар төдийгүй, мөн Халимагийн түүх, соёл, зан заншил, хүмүүсийн амьдралын хэв маягийг багтаажээ. “Би Уэльсд амьдардаг ба олон жилийн турш зэрлэг амьтан сонирхсоор ирсэн. Зэрлэг амьтны талаар хэд хэдэн ч кино хийсэн. Би энэхүү киногоор бөхөн хамгаалалд учирч буй бэрхшээлийг Их Британид дэлгэн үзүүлэх болно” гэжээ. Елеанорын ээж Алисон түүний хажууд ирээд “Би бол зураач, тэгэхээр миний зорилго бол энд харсан бүхнээ зотон дээр буулгах явдал юм. Мөн би байгаль, экологи, газар зүйг үргэлж сонирхсоор ирсэн. Аль хэдийн олон тооны схем гаргачихаад байгаа. Гэртээ харимагц жинхэнэ зурагнуудаа зурж эхэлнэ дээ. Миний зурагнууд Халимагийн тухай санаа бодлоо хэлбэржүүлэх тал дээр хүмүүст туслах болно. Бид бүх дэлхийд хандан энэхүү хосгүй амьтан, түүнд сүүлийн жилүүдэд нүүрлээд буй аюул заналын талаар хэлэхийг хүсэж байна. Их Британид бөхөн гөрөөс байхгүй хэдий ч нэн ховордсон бусад амьтад бий. Энэ нь биднийг нэгтгэж байна” хэмээсэн юм. Олон улсын энэхүү эв нэгдэл нь аль хэдийн эерэг үр дагаваруудыг бий болгож эхлээд байна.

Людмила Сарангова

ӨГҮҮЛЛҮҮД

ИНТАС төсөл амжилтанд хүрэхэд ойрхон байна

Е.Ж.Милнер Гулланд,

Эзэн Хааны Коллеж (e.j.milner-gulland@imperial.ac.uk)



ИНТАС төслөөс санхүүжүүлсэн “Нэн Ховордсон Бөхөн Гөрөөсний Нөхөн Үржихүйн Экологи” сэдэвт 3 жилийн төслийн үйл ажилаагаа 2007 оны 3 сарын сүүлчээр дуусгавар болсон. Уг төсөлд Их Британи, Норвеги, Узбекистан болон Казахстаны (Эзэн Хааны Коллеж, Ослогийн Их Сургууль, Эволюци Экологийн Хүрээлэн, Халимагийн Зэрлэг Амьтны Төв, Узбекистан болон Казахстан улсын Амьтан Судлалын Хүрээлэн, Казахстан улсын ХАА-н Үндэсний Дээд Сургууль) судлаачдыг татан оролцуулсан юм.

Судалгааны зорилго нь Халимаг (Орос)-ийн харьцангуй сайн хамгаалагдсан болон Устюртын (Узбекистан болон Казахстан улсын хил дамнансан популяци) хулгайн анд их хэмжээгээр өртөж байгаа хоёр популяцийн нөхөн үржихүйн зан төрхийн мониторинг судалгааг хийх явдал юм. Эдгээр хоёр популяцийг хооронд нь харьцуулах нь зүйлийн сонгон агнаснаар нөхөн үржихүйн экологид ямар нөлөө үзүүлж буйг үнэлэх боломж олгосон ба энэ нь цаашдын менежментын асуудалд зөвлөмж гаргахад тустай. Төслийн хоёрдугаар чухал бүрэлдэхүүн хэсэг бол бөхөн тархсан улс орнуудад хамгааллын найдвартай менежментийг бий болгох чадавхийг сайжруулах явдал юм. Бид бөхөнгийн хээл авсан эсэхийг тогтоох боломжтой, аюул багатай арга зүйг боловсруулсан ба энэ нь ялгадасны дээжинд гормоны анализ хийх замаар тогтоодог бөгөөд ингэснээр өмнө нь агнаж судалдаг байсан аргыг халах болно. Мөн бөхөнгийн янзагалалт, ороо, сүргийн бүтэц, популяцийн тоог тогтоох боломжтой арга зүйг боловсруулсан ба эдгээр нь бөхөн тархсан улс орнуудын олон жилийн турш явуулсан мониторинг судалгааны үр дүнд үндэслэн харьцуулалт хийж гаргасан стандарт арга зүй юм. Бид мөн өнөө үед популяцийн тооллогыг агаараас хийхэд ашиглаж буй судалгааны төхөөрөмжийн алдааны нарийвчлалыг багасгахын тулд загварчлал ашигласан. Эцэст нь бид бөхөн тархсан улс орнуудын залуу судлаачдыг сургах, мэдээлэл түгээх, харилцаа холбоог сайжруулах зорилгоор байгаль хамгаалагчид болон судлаачдын хооронд сүлжээ байгуулах зэргээр бөхөн хамгаалаллын менежментэд хувь нэмэр оруулсан. Бидний төсөл бөхөн хамгаалал болон эрдэм шинжилгээний судалгаа, олон улсад үлэмж хэмжээний нөлөө үзүүлсэн. Бид хэд хэдэн олон улсын конвенци, ТББ, олон тооны сэтгүүлч, оюутан, хувь хүмүүстэй шинжлэх ухааны зөвлөгөө өгч хамтран ажилласаар ирсэн билээ. Бидний ажил орон нутгийн, үндэсний, цаашлаад олон улсын телевизийн хөтөлбөрүүд, кино, сонингуудаар дамжин олонд түмэнд хүрсэн.

Бөхөнгийн судалгааны менежментэд бидний зүгээс үзүүлсэн өөр нэг нөлөө бол бөхөн тархсан гол гурван улсад зориулан цаашид бөхөнгийн экологийн судалгаанд ашиглах найдвартай арга зүй баталсан явдал юм. Бид урт хугацааны мониторинг судалгааг Халимаг, Узбекистан улсад явуулсан бөгөөд Казахстан улсад одоогоор ашиглагдаж буй мониторинг судалгааны арга зүйг сайжруулахад хувь нэмэр оруулсан. Бидний амжилттай туршиж буй бөхөнгийн хээл авсан эсэхийг тогтоодог аюул багатай арга зүй нь дан ганц бөхөн төдийгүй бусад зэрлэг амьтан судлаачдын анхаарлыг татах нь дамжиггүй. Бид мөн бөхөн тархсан улсуудын засгийн газрыг 2006 онд олон улсын хэмжээнд болсон CMS-ын MOU-ын уулзалтаар бөхөн хамгаалалд татан оролцуулсан бөгөөд ИНТАС төслийн баг шинжлэх ухааны зөвлөхөөр ажиллахаар болсон. Эцэст нь хэлэхэд бид судлаачдын чадавхийг сайжруулахад хүчтэй нөлөө үзүүлсэн ба ялангуяа залуу судлаачид болох Г.Ердненов, Н.Арылова, А.Вознесенская (Орос), Д.Головцов (Узбекистан) нарыг дэмжин ажилласан. Бид мөн залуу судлаач Надежда Арыловаг цаашдын докторантынхаа сургалтанд зориулан Sidney Byers Scholarship хөтөлбөрөөс тэтгэлэг авсныг бахархалтайгаар зарлаж байна.

Бидний төслийн үр дүн олон тооны өгүүлүүд болон нийтлэгдсэн ба хэд хэдэн өгүүлэл нэмж нийтлүүлэхээр төлөвлөдөг байна. Бөхөн мэдээ сэтгүүлийн энэхүү дугаарыг оролцуулан хэд хэдэн өгүүлэл энэхүү сэтгүүлд аль хэдийн нийтлэгдээд байгааг доор жагсаав.

Интернетээс татаж авах боломжтой Англи хэл дээр нийтлэгдсэн өгүүлүүд www.iccs.org.uk

- А.Каал, А.Мистеруд, Ж.И.Ердненов, А.А.Луцкекина, Ю.А.Грачев, А.Б.Бекенов, Е.Ж.Милнер Гулланд. 2007. “The “big spender” of the steppe: sex-specific maternal allocation and twinning in the saiga antelope”, Эзэн хааны нийгэмлэгийн бүтээл Б 274, 1293-1299
- Ж.Диеркс (ред). 2006. “Казахстаны талын гайхамшиг”, Сурагчдад зориулсан ном, Казахстан

Интернетээс татаж авах боломжтой Орос хэл дээр нийтлэгдсэн өгүүлүүд <http://ecoclub.nsu.ru/boch/Stepbull.htm>

- Ю.А.Арилов, В.В.Вознесенская, А.А.Луцкекина, Р.А.Медхидов, Е.Ж.Милнер-Гулланд, Б.С.Убушаев. 2006. “Халимагийн бөхөн гөрөөсний судалгаа болон хамгааллын олон улсын төслүүд”, Степной Бюллетень, Н 21-22, 11-13
- Е.А.Бикова, А.В.Есипов, А.Ю.Ефимов, Д.Е.Головцев. 2006. “Узбекистаны бөхөн: өнөөгийн байдал, популяцийн тоо толгой буурах шалтгаанууд”, Степной Бюллетень, Н 21-22, 2006, 17-20.
- Ю.А.Грачев, А.Б.Бекенов. 2006. “Казахстаны бөхөнгийн популяцийн өнөөгийн байдал, хамгааллын хэтийн төлөв”, Степной Бюллетень, Н 21-22, 15-17

Бид ИНТАС төслийн хүрээнд эхлүүлсэн ажлаа цаашид үргэлжлүүлэхээр төлөвлөж, бөхөнгийн шилжилт хөдөлгөөн, мөн бөхөн хамгаалал болон түүний менежментэд бусад оролцоо байгаа эсэхийг тогтооход чиглэгдэнэ. Харамсалтай нь 12 жилийн турш бөхөнгийн судалгааг дэмжиж байсан ИНТАС төсөл нь цаашдын судалгааг санхүүжүүлэх боломжгүй боллоо. Учир нь Европийн холбоо уг байгууллагын санхүүжилтийг зогсоосон юм. Гэсэн хэдий ч сүүлчийн төслийн хүрээнд буй болгосон нөлөө бүхий сүлжээ нь бидний үр өгөөжтэй хамтын ажиллагааны цаашдын санхүүжилтийн шинэ эх үүсвэрийг бий болгоно гэдэгт бид итгэлтэй байна.



Халимагийн Чёрные Земли Биосфер Нөөц газар дахь бөхөнгийн янзага. 2004 оны 5-р сар. Зургийг Нилс Баннфелд



Залуу эрэмтэн Надежда Арылова цусны дээжинд хээлтүүлгийн шинжилгээ хийж байгаа нь. Зургийг Анна Лушчекина

Устыюрт дахь бөхөнгийн нөхөн үржихүй

Юрий А.Грачев, Аманкул Б.Бекенов
 Казахстан улсын Алмата хотын БШУЯ-ны яам,
 Амьтан судлалын хүрээлэн
 terio@nursat.kz

Энэхүү судалгааг 2004-2006 онд Казахстаны Устыюртын хэсэгт хийж гүйцэтгэлээ. 2004 оны бөхөнгийн төллөлт 5-р сарын 14-нд эхэлсэн бөгөөд 5-р сарын 14-26 ны хооронд бид нийт 595 янзага тэмдэглэсэн. Дөнгөж төрсөн 0.5-2 өдрийн настай янзагануудын биеийн жин 3100-3850 гр, биеийн урт 510-600 мм (n=9) байсан ба 3 дахь өдөр нь эдгээр хэмжилтүүд 3950-4600 гр болон 600-660 мм хүрсэн (n=4). Эр болон эм янзагануудын биеийн хэмжилтүүд нь хоорондоо ялгаа багатай байсан. Тэмдэглэсэн нийт 13 янзагануудын 7 нь эр, 9 нь охин янзага байв. Ихэрлэсэн тохиолдол энэ удаад цөөхөн байсан юм. Нийт 133 тохиолдлын 87 буюу 65%-нь нэг янзагатай, 16 буюу 35%-нь ихэр янзагатай байсан. Иймээс бөхөнгийн нэг шаргагчинд дунджаар 1.34 янзага ногдож байна. Бөхөнгийн популяцийн үр төлөрхөг чанар буурсан нь өнгөрсөн жил нэг бөхөнгийн шаргагчинд 1.5 янзага ногдож байснаас харагдаж байна (янзагалаагүй бөхөнг багтаагаад). Сүүлийн судалгаагаар сувай шаргагчингуудын тоог нарийн тогтоох боломж байсангүй. Учир нь бөхөн төллөлтийн сүүлийн хоёр өдөр бөхөнгийн сүрэг төллөх газраас хойш зүглэн нүүдэллэх үед л шаргагчин, янзаганы харьцааг ажиглалтаар тогтоох боломжтой. Учир нь энэ үед янзаганууд эхийнхээ дэргэд ойр байдаг юм. Энэхүү судалгааны үед бид нийт 334 янзага, 578 шаргагчин тэмдэглэсэн ба өөрөөр хэлбэл нэг шаргагчинд 0.57 янзага ногдож байна гэсэн үг. Янзага шаргагчингийн энэхүү харьцаа бодит харьцаатай ойрхон бөгөөд судалгааны үед шаргагчинтай харьцуулахад цөөн тооны янзага ажиглагдсан.



Устыюртын тал дахь бөхөнгийн нялх янзага.
 Зургийг Маркус Фри

2005 оны 5 сард хамгийн том бөхөнгийн сүрэг Узбекистаны хилээс хойд зүгт 70 км-т орших Косбулак хэмээх давстай, намгархаг газар бүртгэгдсэн билээ. Хэдэн мянган шаргагчин 100-150 км² талбай бүхий уг нутагт бөөгнөрч байсан юм. Энэхүү нутаг нь Косбулакийн хойд хэсгээс баруун тийш сунаж тогтсон бага зэрэг дов сондуултай, давссаг ургамал, үетэн болон заган бут сийрэг тархсан тэгш газар юм. Анхны янзага 5 сарын 12-нд төрсөн ба 5 сарын 14 гэхэд бид 2 өдрийн өмнө төрсөн хэд хэдэн янзагатай тааралдсан. Хамгийн отгон янзага 5 сарын 19-нд мэндэлсэн. Төллөлтийн оргил үе нь 5 сарын 14-17 нд тохиосон.

Хоёр буюу түүнээс дээш өдрийн өмнө төрсөн янзагануудад хэмжилт хийх боломж бидэнд олдсон. 6-12 цагийн настай нийт 13 янзаганы эр янзаганы биеийн жин 2700-3400 гр (дунджаар 3087 гр), охин янзаганых (n=5) 2800-3350 гр (дунджаар 3070 гр) байсан бөгөөд эдгээрийн хооронд ялгаа байсангүй.

Нийт 177 тохиолдлын 126 буюу 71.2% нь нэг, 50 буюу 28.2% нь хоёр, нэг буюу 0.6% нь 3 янзагатай байсан. Эндээс үзэхэд нэг шаргагчинд дунджаар 1.29 янзага ноогдож байна. Дөнгөж төрсөн янзаганы нягтшил 1 км² талбайд 18-35 ийн хооронд хэлбэлзэж байсан. 5 сарын 20, 21 нд зарим янзага эхийн хамт тааралдсан. Бид 32 янзага 131 шаргагчин болон 11 янзага 22 шаргагчин бүхий сүргүүд тэмдэглэсэн. Янзагалалтын үед цаг агаарын байдал тогтуун дулаан байсан учраас янзаганы үхэл хорогдол тэмдэглэгдсэнгүй. Зарим жилүүдэд хүйтэн бороо, сэрүүн цаг агаараас болж янзаганууд энддэг. Гэсэн хэдий ч бид чононд барилдсан 9 янзага бүртгэсэн. Сүүлийн жилүүдэд хийгдэж буй олон судалгаагаар бөхөнгийн янзаганы үхэл, хорогдол цөөн тоогоор бүртгэгдсэн нь тэмдэглүүштэй юм. Үхэж хорогдсон бөхөнгийн янзаганы үлдсэн хэсэг нь талын бүргэдийн үүр орчмоос олдсон.



Юрий Грачев газрын зурагт бөхөнгийн байршлын ажиглалт хийж байгаа нь.
 Зургийг Жин-Франсуа Лагрот

Цөөн тооны бөхөнгийн шаргагчин Асмантайгаас баруун тийш 70 км-т, мөн Канторколын уулархаг нутагт орших Эмба гол, түүнээс баруунтай янзагалж буйтай таарсан.

2006 онд Теренхудукийн цаг агаарын хуучин станцийн ойролцоо хойноос баруун тийш бороо орсон учраас бөхөнгийн сүрэгтэй тааралдана хэмээн найдаж байсан боловч бид уг газарт бөхөн харсангүй. 5 сарын 21 нд нилээд том гэдэстэй хээлтэй шаргагчин бүхий цөөн тооны сүрэгтэй тааралдлаа. Шошжакол нуурын хойд хэсэгт 5 сарын 22 нд ганц янзагатай шаргагчин бүртгэсэн. Бузачийн хойгт 7 янзага 5 шаргагчин бүхий жижиг сүрэг 6 сард тэмдэглэсэн. Эдгээр мэдээг нэгтгэн тооцвол нэг шаргагчинд 1.28 янзага ноогдож байна. Эндээс үзэхэд бөхөнгийн төллөх хугацаа олон жилийн судалгааны дундажтай харьцуулахад өөрчлөгдөөгүй бөгөөд шаргагчин гол төлөв 5 сарын 10-20 ны хооронд өргөн уудам нутгийг хамран төллөдөг. Бөхөнгийн үр төлөрхөг чанар муудсан нь нэг шаргагчинд ноогдох янзаганы тооноос харагдаж байгаа бөгөөд 1990 ээд оны үед 1.50 байсан бол сүүлийн жилүүдэд 1.28-1.34 болж буурлаа. Өмнө нь бөхөнгийн шаргагчингийн 75% ихэрлэж, 25% нь ганц янзага төрүүлдэг байсан. Сүүлийн жилүүдэд нөхцөл байдал эсрэгээрээ өөрчлөгдөж байгаа ба зөвхөн 28% нь ихэрлэж байна. Үр төлөрхөг чанар муудаж буй гол шалтгаан бол үржлийн насны ооно цөөрсөн явдал ба энэ нь сувай шаргагчингийн тоо есөхөд хүргэж байна. Ихэрлэлтийн хэмжээ багасч буй явдал нь бөхөнгийн популяцийн бүтцийг өөрчилж, үр төлөрхөг чанар багатай залуу шаргагчингийн эзлэх хувь ихсэх замаар илэрч байна.


Энэхүү судалгааг ИНТАС 3579 төслийн санхүүжилтээр хийж гүйцэтгэв.

Бөхөнгийн филогеографи

Марина В.Холодова
Оросын Шинжлэх Ухааны Академийн Экологи, эволюцийн хүрээлэн
mvkholod@mail.ru


Бөхөнгийн генетик олон янз байдлын түвшин, түүхэн хугацаанд тоо толгой, байршил нутаг өөрчлөгдөж байгааг судлаачид тэмдэглэсэн ба (Банников нар 1961, Барышников нар 1998), одоо байгаа бөхөнгийн тусгаар популяцуудын хоорондох холбоо хамаарал тодорхой бус байна. Нөгөөтэйгүүр монгол бөхөнгийн гарал үүсэл, статусын талаарх асуудал одоогоор бүрхэг хэвээр байна. Зүйлийн филогеографийн бүтцийг судлах, генетик олон янз байдлыг тодорхойлохоор янз бүрийн бөхөнгийн популяцаас цуглуулсан дээжинд ($n=93$) үндэслэн ДНХ митохондрийн Д-муруйн хувьсах хэмжигдэхүүний полиморфизмийн шинжилгээг хийлээ. Үүнээс 52 гаплотип тодорхойлсон. Дээжийн 36.6% нь нэгэн хэвийн гаплотиптэй байв. Ерөнхийдөө зүйлийн гаплотип ($H=0.98\%$), нуклеотид ($\pi=3.7\%$) олон янз байдал хивэгчдийн дундаж үзүүлэлтээс бага зэрэг өндөр байна. Бодгалийн гаплотипын хоорондох статистик ялгаа, мутацийн өөрчлөл, ялгаатай бүс нутгийн амьтдын тоо толгой нь бөхөнгийн ДНХ митохондрийн орчин үеийн полиморфизмийн өөрчлөлтийн түүхэн урт хугацааг илэрхийлэхээс гадна эрт дээд үеэс бөхөн нэг эволюцийн шугамтай байсан гэсэн таамаглал бий болгож байна (Барышников нар 1998).

Генетик олон янз байдал бөхөнгийн популяцуудын хооронд өөрчлөгддөг. Хамгийн өндөр генетик өөрчлөлт Устюрт болон Бетпақдалагийн популяцид тэмдэглэгдсэн харин монгол бөхөнд 3-5 дахин бага байсан. *S.t.tatarica* хэмээх дэд зүйлийн генетик олон янз байдлын хадгалалт нь популяцийн бууралтын үеэс үл хамааран зүйлийн нөхөн төлжилтэй холбогдон илэрдэг. Европ болон Казахстаны бөхөнгийн популяцийн хоорондох полигенетик хамаарлын судалгаагаар бөхөнгийн тусгаар дэд зүйлүүдийн хооронд их ялгаа бий нь ерөнхийдөө одоо байгаа дэд зүйлүүд цорын ганц өндөр полиморфик эх популяцаас үүссэн гэсэн дүгнэлт гарч байна. Популяци хоорондын генетик түгэлтийн үнэлгээгээр бусад популяцтай харьцуулбал монголын популяци хамгийн өндөр генетик тусгаарлалтанд орсон харин Устюрт болон Бетпақдалагийн популяцуудын хооронд бодит ялгаа байхгүй гэсэн үзүүлэлт гарч байна (зураг 1). Тиймээс газарзүйн тусгаарлалтаас үл хамааран Казахстаны бөхөнгийн популяцын бодгалиудын нүүдлийн замнал өөр байдаг (Фадеев, Слудский 1982, Бекенов, Грачев 1998). Бидний судалгаагаар тэдгээрийн хооронд ойрын холбоо байгааг илрүүлэв.



Зураг 1. Генетик түгэлтийн хэмжилтэнд үндэслэсэн *Saiga tatarica*-ийн популяцуудын хоорондох генетик түгэлт (Торон түгэлт)

Казахстаны популяцийн үндсэн генетик холбооноос үл хамааран Казахстаны 3 популяцид ердийн гаплотип бүртгэгдсэн бол Европын бөхөнд Казахстаны бөхөнтэй ижил гаплотип бүртгэгдээгүй байна. Ижил (Волга) мөрөн нь бөхөнгийн популяцийн баруун (Европын популяци) зүүн (Казахстаны популяци) хэсгийн хооронд хүчтэй саад хаалт болж чаддаг. Хэдийгээр бөхөн заримдаа Волга мөрний нэг эргээс нөгөө эрэгт (ихэвчлэн өвлийн улиралд тэжээл хомсдосоноос, Банников нар 1961) нүүдэллэдэг хэдий ч популяцуудын хоорондох генетик солилцооны нөлөө нь эхийн талд байдаг нь ач холбогдол муутай юм. Хүний зүгээс үзүүлж буй хүчин зүйл нь *S.t.tatarica* дэд зүйлийн популяцийн бодгалиудын тусгаарлалтанд онцгой нөлөөлдөг ажээ. Хүний хийсэн саад хаалт нь популяци хоорондын нүүдэлд нөлөөлдөг бөгөөд 1980-1990-ээд онд Казахстанд тэмдэглэгдсэн билээ (Бекенов нар 1998). 20-р зууны сүүлч 21-р зууны эхэн үеийн бөхөнгийн популяцийн тоо толгойн огцом бууралтыг авч үзвэл генетик болон газарзүйн тусгаарлалт өсөх хандлагатай байна.



Молекул генетикийн мэдээнээс үзвэл Казахстаны бөхөн үүсэн бий болсон эх сүргийн хэлбэртэй нилээд төстэй байна. Казахстаны бөхөнгийн гаплотип нь хувьсах чанар өндөртэй, филогенетик модон дээр тэдгээрийн ихэнх нь үндсэн байршлыг эзэлж байна (зураг 2). ДНХ митохондрийн полиморфизм анализар одоогийн тархац нутаг төв Казахстан нь бөхөнгийн тархцын үндсэн төв байсан гэсэн дүгнэлт гаргах боломжийг олгов. Монгол бөхөн *S.t.mongolica* генетик хувьсах чадвар багатай, дээд өвгөөсөө тусгаарлагдсан, бага тоо толгойтойгоор урт хугацааны турш оршиж байгаа юм. Монголын дэд зүйл анатоми шинж чанараараа нялх, морфологи шинж чанараараа биеэр жижиг, тоо толгой харьцангуй бага зэрэг шинжээрээ бусад бөхөнгөөс ялгагдаж байгаа нь дээрх зүйлтэй тохирч байна. Энэхүү судалгааг Оросын суурь судалгааны сан ИНТАС төсөл 97-11197, Сан-Диего хотын амьтан судлалын нийгэмлэг санхүүжүүлэв. Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл Холодова нарын 2006 оны Огух сэтгүүлийг www.iccs.org.uk хаягаар орж авна уу!

Зураг 2. Тусгаар популяцуудын гаплотипын дундаж үзүүлэлт. Гаплотипын бүдүүвч: цагаан-Европын бөхөн, саарал-Казахстан, хар-Монгол. Бөөрөнхий тэмдэгтийн диаметр нь гаплотип дээжийн тооны харьцаа. Шугам нь үүссэн байх боломжтой эх сүргийн зүгийг харуулж байна (*Cobus kob*-ийн ДНХ митохондрийн ижил хэсгүүд гадаад бэлгэ болон ашиглагдсан).

Астрахань мужийн “Степной” нөөц газрын бөхөн хамгаалал

Анатолий В.Хлуднев

Орос улс, Астрахань муж, “Степной” нөөц газар angelok-19@yandex.ru

Каспийн баруун хойно, Астрахань мужийн баруун өмнө хэсэгт хялгана зонхилсон тал хээрийн экосистем бий. Энэ бүс нутаг хүний нөлөөнд бага өртсөн, талын бүргэд, тарлан сар, өвөгт тогоруу, тоодог, бөхөн зэрэг ховор хөхтөн, шувуу, ургамлын зүйлээр элбэг нутаг юм. Бөхөнгийн тоо толгой 1990-ээд онд буурснаар байгалийн нөөц газар бий болгож энэ амьтан болон бусад зүйлийг хамгаалах санаачлага өрнөсөн. Энэ санаачлага үр дүнтэй болж Астрахань мужийн захирагч А.П.Гузвин Астрахань мужийн Лиман дүүрэгт 87.000 га газар нутагт нөөц газар байгуулах 2000 оны 4-р сарын 5-ны өдрийн №120 тогтоол гаргасан. Тус нөөц газрын үндсэн зорилго нь хулгайн агнуурыг таслан зогсоох, бөхөнд учирч буй аюул заналаас сэргийлэх, орон нутгийн хүмүүсийн мэдлэгийг дээшлүүлэх, сэрэмжлүүлэн сануулах, хээл хахуулийг зогсоох хууль дүрэм батлах, судалгааны ажлыг дэмжих зэрэг болно. Нөөц газарт 10 албан хаагч ажилладаг. Байцаагч нар радио холбоо, шөнө харах багажаар тоноглогдсон 4 машин, Кавасаки, Ямаха фирмийн 2 спорт мотоцикл, буу, чиг заагч багаж, дуран, зургийн аппарат болон бусад хээрийн багаж хэрэгслээр хангагдсан. Байцаагч нар хуулийн талын сургалт, буу зэвсэг, багажийг аюулгүй хэрэглэх заавар зөвөлгөөг байнга авдаг. Нөөц газар үүсэн бий болсон анхны өдрөөс эхлэн тойрогчилсон хяналтыг 2 машинтайгаар хийж эхэлснээр эерэг үр дүнгээ даруй өглөө.



Байгаль хамгаалагчид тал нутагт хяналт шалгалт хийж байгаа нь. Зургийг Анатоли Хлуднев



Хулгайн анчдын “хар дарсан зүд” болсон В.Калмиков. Зургийг Анатоли Хлуднев

Байгаль хамгаалагчид тус бүс нутагт хууль бус агнуур хийдэг хулгайн анчдыг мотоциклтой явж байхад нь харсан даруйдаа хурд хүч сайтай мотоциклээр элдэн хөөж зогсоож чаддаг. Бөхөн хамгаалах үйл ажиллагааг олон арга зүйгээр хийлээ. Тухайлбал бүс нутагт машинаар явж хяналт шалгалт хийх, хулгайн анчдийг хийх боломжтой замыг отох, хяналтын цэг болон замын уулзварыг хянах зэрэг юм. Тусгай хамгаалалттай газар нутгийн доторх бөхөнгийн байршил нутгийн өөрчлөлт болон бусад хэрэгцээтэй мэдээллийг хоньчидтой хамтарсан судалгаагаар цуглуулж авлаа. Үхрээ алдсан фермийн эзэд бидэнтэй гар утсаар шууд холбогдон мотоциклтэй сэжигтэй хүнийг дахин дахин мэдээлж зохистой арга хэмжээ авах боломжийг бий болгодог. Хулгайн анчид маш сайн тоноглогдсон техник хэрэгсэл, гар утас ашигладаг мөн БНХалимаг улсын ангийн захиргааны байцаагч, байгаль хамгаалагчийн гадаад байдлын талаар нэг нь нөгөөдөө мэдээлж байдаг. Тиймээс байгаль хамгаалагч нар хяналтын хэсэг рүү нуугдан ойртож шөнийн ажиглалтыг хийх ёстой болдог.

Хяналтанд явах хуваарьгүй хугацаандаа байцаагч нар орон нутгийн сургууль, коллеж, номын сангаар орж өөрсдийн хийсэн кино зургийг үзүүлж улирал болгон нөөц газрын нөхцөл байдлын талаар өгүүлэл хэвлүүлж байна. 2006 оны 6-р сард Оросын телевизийн СТС сувгийн сурвалжлагч бидний дүрс бичлэгт үндэслэн кино хийж астрахань телевизээр үзүүлсэн нь маш үр дүнтэй болсон. Бөхөнгийн талаарх мэдээллүүд Астрахань хэд хэдэн сонинд нийтлэгдлээ. 2007 оны 2-р сард Астрахань радио телевизийн Лотос компани нөөц газрын бөхөн хамгаалал, чонын тоог хянах ажлын талаар 2 жижиг хэмжээний баримтат кино хийжээ. Тус 2 кино олон нийтийн сайшаалыг хүртсэн юм. Нөөц газар, албан хаагчдын талаарх том хэмжээний өгүүлэл 2007 оны 2-р сарын 14-нд “Комсомолец Каспия” сонинд хэвлэгдэв. Нөөц газрын байгаль хамгаалагч нар гадаад дотоодын эрдэмтэн судлаач, оюутнуудын судалгааны ажилд тусалж байна.

Сүүлийн 3 жилийн турш байгаль хамгаалагч, байцаагч нар тусгай хамгаалалттай газар нутгийн бөхөнгийн талаар мониторинг судалгаа хийж тайлан бичиж байна. Бүх мэдээллийг цуглуулсан бөгөөд хэрэгцээт мэдээллийг бөхөнгийн тархцыг тодорхойлох мониторинг мэдээллийн санд илгээж байгаа юм. Тиймээс бид судалгааны бүс нутгийн бөхөнгийн тоо толгойн жилийн болон улирлын өөрчлөлтийг хянах боломжтой болж байна. UNESCO/MAB-ын Оросын хороо, “Чёрные земли” шим мандлын нөөц газар, БНХалимаг улсын Зэрлэг амьтдын төвтэй нягт хамтран ажилласны үрээр “Степной Санктуар”-ын ажилчид олон улсын байгууллага болон Оросын олон байгууллагуудтай хамтын ажиллагаа, судалгааны ажлын сэжмээр холбогдож байна. Тиймээс бид доктор Анна Луцкекина, профессор Юрий Арылов нарын удирдлагын дор бөхөн судлах, хамгаалах төслийн нэг үндсэн гишүүн болж чадлаа. “Степной Санктуар”-ын ажилчдын гүйцэтгэсэн бөхөн хамгаалах үйл ажиллагаа, орон нутгийн хүмүүстэй хамтран ажиллах санаачлага нь IFAW, PTES, INTAS болон “Дарвины санаачлага” зэрэг олон улсын байгаль хамгаалах байгууллагуудын дэмжлэгийг авах боломжийг олголоо. Энэхүү боломжийг авснаар “Степной Санктуар”-ын бүх албан хаагчдын нэрийн өмнөөс бөхөн зэрэг цорын ганц зүйлийг хамгаалах үйлсэд тусалж буй бүх байгууллага хамт олонд чин сэтгэлийн талархал илэрхийлье. Бөхөнгийн тоо толгойн бууралт зогсон аажмаар өсөж байгаа нь бидний ололт юм. Тиймээс Каспийн бүс нутгийн баруун хойд хэсэгт буй бөхөнгийн одоогийн тоо толгой 1000-н бие гүйцсэн оонотой 20.000 илүү бодгальд хүрч байна. Бидний ажил ирээдүйн бөхөн хамгаалах ажилд тус дэм болно гэж найдаж байна.

Бөхөнгийн нутгаар тойрсон дурсамж дүүрэн аялал

Стасей Айверсон

АНУ-ын Зэрлэг амьтан хамгаалах сүлжээ.

stacey@wildnet.org

Стасей Айверсон, Зэрлэг амьтан хамгаалах сүлжээний хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн, түүний нөхөр Кейт (Кип) Айверсон, Зэрлэг амьтан хамгаалах сүлжээний компьютер технологийн сайн дурын ажилтан нар 4, 5-р сард 2 долоо хоногийн хугацаатай Орос, Халимаг, Узбекистан дахь Бөхөн хамгаалах холбооны төслүүдээр зочилсон байна.

Орос хэлний харилцан ярианы дэвтэр, сайн чанарын дижитал аппарат барьсан Кип бид хоёр төв Азийн аялалаа эхэлсэн юм. Бид Африк, өмнөд Америкт амьдарч, аялж байсан гэвч энэ бол бидний Төв Азид хийсэн анхны аялал байлаа. Александр Эсипов, Елена Быкова нар биднийг Ташкентад халуун дотноор хүлээн авч Лада жийлэнд тухлан сууж эртний торгон замын дагуу бидний аялал хөвөрч эхэллээ. Төд удалгүй бид холбоонд ажилладаг амьтан судлаач, оюутан Дмитрий Головцов, Гайрат Сайдов нартай нэгдэв. Аяллын туршид тэд хуучин мөртлөө бат бөх суудлын машинаар чадварлаг мэргэжилтнүүд төдийгүй найдвартай хүмүүс гэдгээ батлан харуулсан юм. Бидний хүрсэн хамгийн алсын нутаг бөхөнгийн сүргийн нүүдлийн түүхэн замнал болох Узбекистаны баруун хил орчмын Каракалпакстанын муж байсан. Харамсалтай нь энэ бүс нутагт хулгайн ангийн нөлөөгөөр бөхөн урт хугацаанд үржиж чадаагүй байна. Бөхөнгийн сүрэг зөвхөн өвлийн улиралд энэ нутагт нүүдэллэн ирдэг. Салхи богинохон өвсийг чимээгүй хөдөлгөн байгаа ч тэнгэр газар бээрийн дайтай цэлийн харагдаж байлаа. Би энд илүү удаан байж зуу зуун жил мориор, тэмээгээр, явганаар энэ замаар аялсан хүмүүсийн талаар илүү ихийг мэдэхийг, энд амьдарч буй зэрлэг амьтдын талаар төсөөлөн бодохыг хүссэн. Энэ том тал нутгийн зам маш урт, зураг авахаар байн байн зогсож цаг их алдаж байлаа. Замын хажуугаар ургасан улаан намуу цэцэг, уугуул мэрэгчтэн, ургамал, шавжаар хооллож буй шувууд, бүх төрлийн өнгө зүстэй хонин сүрэг, бэлчиж буй аварга том номхон тэмээд, заримдаа илжиг, адуу зэрэг нь сонирхол татаж байсан. Замын хоол үргэлж сонирхолтой, амттай байсан нь бидний аяллын адал явдалтай салшгүй нэгэн хэсэг байлаа. Зам дагуу бид Самарканд, Бухар, Нукусд хоноглосон. Хот болгон өөрийн гэсэн сэтгэл татам зүйлтэй, тухайлбал, гараар хийсэн цэнхэр цагаан өнгийн шигтгэмэл тоосгоор бүрсэн гайхамшигт лалын сүм юм. Эдгээр лалын сүмийн түүх эртний соёл иргэншил, харийн соёлын зүйлсийг тусгасан байна. Бүх хотуудын зочломтгой зан, орон нутгийн ая тухтай ор, өглөөний цай бидэнд таалагдсан. Бухарын өглөөний цайн дээр тус нутагт ургадаг сарнайнаас гаргаж авсан жимсний чанамал хамгийн өндөр сэтгэгдэл төрүүлсэн.



Узбекистан нутгийн хайр талархал – Зам зуур хэдэн тэмээтэй тааралдах цед авсан зураг. Зургийг Кейт Айверсон

Узбекистаны 4 дахь өдрийн аяллаар бид Каракалпакия тосгоны оршин суугч Дамиш болон Мишагийн гэрт зочилсон. Миша өмнө нь бөхөнгийн анчин байсан одоо бөхөнгийн найз болж зэрлэг амьтан хамгаалах ажилд оролцож байна. Бид тосгоны дунд сургуульд зочлон бөхөнгийн гар зургийн уралдааны ялагчыг тодруулав. Сургуулийн сурагчдын дунд авъяаслаг зураач хүүхэд байдгийг мэдэж нутгийн хүүхдүүдэд зориулан бөхөн хамгааллын талаар чухал хичээл бий болгох хэрэгтэйг тэмдэглэв. Бидний дараагийн чиглэл Устюртын тал хээрт байх Белуйлын балгас байлаа. Балгас нь эртний зочид буудлаас үлдэж хоцорсон бөгөөд торгон замын хажууд байдаг. Сүүлийн үед бөхөн энэ нутагт үржих болжээ. Балгасын ойролцоо жижиг нуур байдаг, тал бүр тийш үл дуусах их тал үргэлжилнэ. Энэ уудам тал нутагт бүх юм нэгдэн байх учиртай тул ганцаар байх нь хэцүү. Би тэнд удаан байж чадсангүй. Бид Елена, Александр нарт сайн суухыг ерөөгөөд Анна Лушечкинтай уулзахаар Москва руу ниссэн. Аяллын энэ хэсгийн бидний зорилго Оросын бөхөн судлаачдын багтай уулзах, Халимаг дахь бөхөн үржүүлэх төвөөр зочлох байсан.

“Степной Санктуар”-ын захирал Надежда болон Анатолий Хлуднев нарын гэрт эхний шөнийг өнгөрөөв. Энэ нутаг биднийг мөн л халуун дотноор хүлээн авсан. Дараагийн өдөр бид “Степной Санктуар”-руу явлаа. Хээр тал бол мэрэгчтэн болон тэдний дайсан харцага, бүргэд, шонхорт таатай орчин болжээ. Хамгийн сэтгэл хөдөлгөсөн зүйл нь задгай тэгш тал нутагт бүрэн зохицсон зэрлэг бөхөн эрх чөлөөтэй хатирч байхыг харсан явдал байв. Хулгайн антай тэмцэх багийн хэд хэдэн хүмүүстэй уулзаж энэ өргөн уудам дархан газарт тэдний хийх ёстой ажлын талаар ойлголтоотой болов. Энэ бүс нутгийн хулгайн анг 7 хүрэхгүй жилийн хугацаанд зогсоож чадсан тул бөхөн төдийгүй бусад эндемик амьтанд энэ бүс нутаг нь хамгийн чухал үржлийн газар болон хамгаалагджээ. Бидний аялалын хамгийн сүүлд саатсан газар бол Халимагийн зүрхэн газар байдаг бөхөн үржүүлгийн төв байлаа. Тус үржүүлгийн төвийн захирал профессор Юрий Арылов анх цөөхөн бөхөнтэй энэ ажлыг эхэлжээ. Ойролцоогоор 40 бөхөн томоохон хэмжээтэй хашаанд байж тавцангаас зочдод харуулдаг байна. Бөхөн сайн хамгаалагдсан боловч хүний нөлөөнд орж байгаа нь хагас-зэрлэг байдалд байна гэж хэлж болохоор байна. Үйл ажиллагааны бүх нөхцөл байдал нь хүн болон амьтныг өрөвдөн энэрэх сайхан харьцааг агуулж байна. Зочдын танхимыг байгуулсан хэвээр байгаа хэдий ч нутгийн сургуулийн хүүхдүүдийн хийсэн гар урлал, хүн болон бөхөнгийн хоорондын амьдралын харилцаа, орон нутгийн соёл иргэншлийг тодорхойлсон боловсролын үзүүлэн зэргийг багтаасан гэртэй болжээ. Энэхүү аялал мартагдашгүй зүйлээр дүүрэн байсан. Эзэн хүмүүсийн халуун дулаан, өгөөмөр сэтгэл, мөн “Степной Санктуар”-д бөхөн эрх чөлөөтэй давхиж байхыг үргэлж санах болно. WCN-ийн Бөхөн хамгаалах холбооны хөтөлбөр хариуцсан мэргэжилтний хувьд бөхөнгийн талаар бусадтай мэдээлэл, туршлага солилцох боломжтой боллоо. Бөхөн хамгаалах холбоо болон Еленатай урт хугацааны турш амжилттай хамтран ажиллана хэмээн найдаж байна.



Оросын Бөхөн үржүүлэх Халимаг дахь төвийн захирал Юрий Арылов болон Кейт, Стэси нар ноосоор хийсэн, ханын гар хийцийн гоёл барьж байна. Зургийг Зургийг Анна Лушечкина

Төслийн эргэн тойронд

Узбекистаны бөхөн хамгаалах төсөлд орон нутгийн иргэдийн оролцоо

Узбекистаны бөхөнгийн популяцийн бууралтын гол хүчин зүйл нь хулгайн ан юм. Бөхөнгийн эвэр, махыг орон нутгийн хүмүүс зарах буюу хувийн хэрэгцээнд ашигладаг. Агналтын хамгийн идэвхтэй үе нь 10-р сараас 2-р сар хүртэл буюу бөхөнгийн нүүдэл Узбекистанруу түрж эхлэхтэй зэрэгцдэг. Хулгайн ан хийх үндсэн шалтгаан нь ядуурал, бага орлоготой, ажил эрхлэлт бага, хууль бус агнуурын шалгалт муу зэргээс шатгаалж байна. Бөхөнгийн мах, арсны тасралтгүй хэрэглээ, тухайн нөхцөл байдлын ойлголт муу байгаа нь хулгайн ан ихсэх бас нэг шалтгаан болж байна. 2007 оны 1-р сард орон нутгийн хүмүүсийн боловсролын түвшинг дээшлүүлэх, тус зүйлийн менежементийг сайжруулахад хүмүүсийн оролцоог дэмжих бөхөнгийн хамгаалалд хандсан 2 төсөл үйл ажиллагаагаа эхэлсэн.



Яслик тосгонд бөхөнгийн "андууд"-тай арилцаж байгаа нь. Зургийг Елена Быкова



Каракалпакиа тосгоны 56-р дунд сургуулийн охид бөхөнгийн сэдэвт гар урлал бүтээж байна. Зургийг Александр Есипов



1. Бөхөн хамгаалах менежементэд зориулсан орон нутгийн нийгэмлэгүүдийг байгуулах нь

Олон улсын амьтан, ургамлын аймгийг хамгаалах нийгэмлэг (FFI), Узбекистаны Шинжлэх Ухааны Академийн Амьтан судлалын хүрээлэн уг төслийг British American Tobacco компанийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хийсэн байна. Төсөл бөхөнгийн мониторинг ажиглалтанд орон нутгийн хүмүүсийг татан оролцуулахад чиглэгдсэн. Ажиглалтын бүлгүүд хуучин анчин байсан хүмүүс болон одоо ан хийж буй хүмүүсээс бүрджээ. Одоогийн байдлаар Яслик, Каракалпакиа тосгонд 2 бүлэг бий болж мониторинг судалгаа хийх сургалтад хамрагдаад байна. 2006 оны 10-р сараас 2007 оны 3-р сар хүртэл бөхөнгийн экологийн талаар, тухайлбал, нүүдлийн хугацаа, тоо толгой, тархац, сүргийн хэмжээ, популяцийн бүтэц, зан төрхийн холбогдолтой мэдээлэл цуглуулжээ. Мэдээлэл цуглуулах хэлбэрийг бөхөнгийн нөхөн төлжлийн экологийн судалгааны ИНТАС төслийн боловсруулсан мониторинг протоколд үндэслэн боловсруулсан (дээрх өгүүллийг үзнэ үү). Бидний өөр нэг зорилго нь үндэсний байгаль хамгаалах агентлагтай хамтран боловсруулсан оршин суугчдын дунд явуулсан хэлэлцүүлгийг ашиглан бөхөнгийн зохистой хэрэглээ, хамгааллын талаарх сурталчилгааг нэмэгдүүлэх явдал юм.

2. Бөхөн хамгаалалд орон нутгийн хүмүүсийг оролцуулах, сурталчилгааг нэмэгдүүлэх нь

Бөхөн хамгаалах холбоо уг төслийг ВСН, Сидней Баерсийн Итгэлийн Сан болон бусад хандивын тусламжтайгаар гүйцэтгэв. Энэ төсөл бөхөн хамгаалах тогтвортой сүлжээг бий болгох, сурталчилгааг нэмэгдүүлэх зорилготой. Бидний үйл ажиллагааны тэргүүн зорилго Яслик, Каракалпакиа, Кубла-Устюрт тосгоны бөхөнгийн мах, эврийн хэрэглээнд шууд хамааралтай оршин суугч нартай холбоо тогтоон хамтран ажиллах явдал байв. Бид одоогоор сургуулийн сурагчид болон оюутнуудын дунд боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлж, сургуулийн гар урлалын клуб байгуулах, ном, зурагт үзүүлэн хэвлэх, орон нутгийн сайн дурынхантай хамтран ирээдүйн бөхөнгийн найз, бөхөн хамгаалагчидтай ажиллаж байна.

Сургалт сурталчилгаа, бөхөн хамгаалах талаар орон нутгийн хүмүүсийн сонирхолыг нэмэгдүүлснээр бид Устюртын биологийн олон янз байдлын урт хугацааны үндэс суурийг тавьж байгаа юм. ВСН-ийн төслийн өөр нэгэн чухал хэсэг нь бөхөнгийн мэдээ сэтгүүлийг дэмжин, бөхөн хамгаалах холбоог хөгжүүлэх, энэ оны 9-р сард БХХ-ны удирдах зөвлөлийн хурлыг Ташкентад хийх зэрэг юм. Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл Елена Быкова болон Александр Есиповтой холбоо барьна уу. esip@tkt.uz

БХХ нь бөхөнгийн хамгаалах Харилцан ойлголцлын баримт бичгийн (MOU) хэрэгжилтийг хянах байгууллага мөн

Дараагийн 5 жилд хийх үйл ажиллагааны дунд хугацааны ажлын төлөвлөгөөний хэлэлцээр, бөхөн хамгаалалд MOU-ийн хэрэгжиж байгаа тухай мэдээллийг бид дугаар 4-т нийтэлсэн. MOU-ийн дараагийн хурал 2 жилийн дараа болох юм. Мэдээллээ солилцон, бөхөнгийн мэргэжилтэн, төслийн мэдээллийн санг нэгтгэн дунд хугацааны ажлын төлөвлөгөөг бий болгоход зориулан CMS бидэнд "Бөхөнгийн мэдээ" сэтгүүл гаргах эрх олгосон билээ. Иймээс дунд хугацааны ажлын төлөвлөгөөний зорилго, үйл ажиллагааны талаар редакцийн зөвлөлийн бичсэнийг одооноос эхлэн "Бөхөнгийн мэдээ" сэтгүүлд жижиг хэсэг болгон оруулах шаардлагатай болж байна. Ямар нэгэн хамааралтай хийгдэж буй үйл ажиллагааны талаар бидэнд мэдэгдэхийг хүсье. Мэдээллийн санд хэн эксперт байх талаар мэдэгдэж холбогдох хаягыг бидэнд өгнө үү. Бөхөнгийн мэдээнд оролцогч бүхэн дунд хугацааны ажлын төлөвлөгөөнд орсон өгүүллүүдийг хэрхэн тайлагнах талаар богино хэмжээний тайлбарыг хийх шаардлагатай болж байна. CMS-д өгөх бидний сүүлчийн тайлан дунд хугацааны ажлын төлөвлөгөөний дагуу үүрэг хариуцлага тархалтын бүс нутгуудад бүрэн биелүүлсэн баримт бичиг үйлдэх болно. Ингэснээр бөхөн хамгаалалд хүчин зүтгэж буй хүмүүс өөрсдийгөө үнэлүүлэх боломжтой болно.

2006 оны 9 сараас 2007 оны 6 сар хүртэлх хугацаанд CMS-ийн Харилцан ойлголцлын гэрээнд заагдсан үйл ажиллагааны тайлан

Бүлэг 1. Гүйцэтгэл

Олон улсын түвшинд. БХХ нь "Бөхөнгийн мэдээ" сэтгүүлийн хэвлэлтийг ЗАХС, "Дарвины санаачлага", ИНТАС төслийн дэмжлэгтэйгээр энэ хугацаанд хэвлэж байна. НЗХОУКонвенци (CMS) 2007 оны 7-р сарын 1-ээс эхлэн Лондоны эзэн хааны колледжд олгосон 2 жилийн грантын дагуу дунд хугацааны ажлын төлөвлөгөөний үйл ажиллагааны талаарх мэдээллийн харьцуулалтыг дэмжиж байна (үйл явц 1.5).

Узбекистанд. Дунд хугацааны ажлын хөтөлбөрийн дагуу бий болсон Харилцан ойлголцлын гэрээний гүйцэтгэлийн хороог бий болгож 2006-2010 онд хийгдэх бөхөн хамгааллын талаар нэн тэргүүнд хийгдэх ажлын хөтөлбөр дээр ажиллаж байна (үйл явц 1.2, 1.3).

Казахстанд. Казахстаны ерөнхий сайдын тамгын газрын даргын 2007 оны 2-р сарын 20-ны №7-64/002-565 тоот тушаалын дагуу ХАА-н яамны амьтны эдлэн газар, ойн хороо, Амьтан судлалын хүрээлэн 2008-2010 оны хооронд бөхөн болон устаж буй зэрлэг туруутны хамгаалал, нөхөн сэргээлтийн хөтөлбөрийн 2-р шатны баримт бичгийг хэрэгжүүлж байна (үйл явц 1.2).

Бүлэг 2. Хууль бус агнуурын эсрэг үйл ажиллагаа

Бөхөн тархсан аль ч улсад хулгайн ангийн эсрэг үйл ажиллагааны санхүүжилтэнд дэвшил гарсангүй.

Орос. IFAW-ийн жижиг грантыг "Степной Санктуар" авч тус дархан газрын байгаль хамгаалагчдын чадавхийг нэмэгдүүлэх бодит тусламж (үйл явц 2.2), сургалт (үйл явц 2.4) зэргээр бөхөнгийн хамгаалал, мониторинг судалгааг дэмжсэн. Халимагт 2007 оны 3 сард 2 хулгайн анчин баригдаж, шүүгдсэн. Мөн Орос, Тайван, Казахстан зэрэг улсад хулгайгаар эвэр зөөж байсныг илрүүлсэн (үйл явц 2.3, дээрх өгүүллийг хар). **Монголд.** 2006 оны 9-р сард байгаль хамгаалагч нарт зориулсан сургалт болсон (Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар, бөхөнгийн мэдээ дугаар-4, үйл явц 2.4)

Бүлэг 3. Зохистой хэрэглээ болон худалдаа

Олон улсад. 2007 оны 6-р сард CITES-ийн амьтны хороо хурлаараа бөхөн авч хэлэлцсэн, ЗАХН болон ТРАФИК-аар удирдуулсан үйлдвэрлэгч болон хэрэглэгч орнуудад худалдааны талаар судалгаа хийсэн дүнг танилцуулсан.

Бүлэг 4. Хүний хүчин зүйл

Төслүүдээс гадна дараах үйл ажиллагаанууд тухайн хугацаанд хийгджээ:

Узбекистанд. FFI/BAT болон ЗАХС санхүүжүүлэн Амьтан судлалын хүрээлэн, БХХ-ны гүйцэтгэсэн мониторинг судалгааны шинэ төсөл эхэлж "Бөхөнгийн найзууд" хэмээх сүлжээг бий болгосон (дээрхийг харна уу, үйл явц 4.2, 4.3).

Халимагт, бөхөн хамгааллын байдал, хамгааллын төслийн үр нөлөөний талаарх судалгааг 2006 оны 10-11 сард Дарвины санаачлага санхүүжүүлэн Лондоны эзэн хааны коллеж, Экологийн төслүүдийн төв хамтран гүйцэтгэсэн (үйл явц 4.2). “Нийгмийн шашны нийгэмлэг” санхүүжүүлэн Халимагын Дарма төвөөр ахлуулсан төсөл бөхөн хамгаалалд шүтлэгтэй хүмүүсийг оролцуулж байна (үйл явц 4.3). Казахстанд, FFI 2006 оны 10-р сард Босой, Устюртад жижиг тэтгэлэгийн хөтөлбөрийн 2-р үе шатыг эхлүүлсэн (үйл явц 4.1, БМ дугаар 4).

Бүлэг 5. Сургалт сурталчилгаа

Төслүүдээс гадна дараах үйл ажиллагаанууд тухайн хугацаанд хийгджээ:

Монголд, 2006 оны 10-р сард WWF-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар хүүхдүүдийн дунд гар зургийн уралдаан зохион байгуулжээ (БМ дугаар 4, үйл явц 5.2).

Узбекистанд, гар урлалын клуб байгуулан, сурталчилгааны материал хэвлэхийг дэмжиж гар урлалын уралдаан зохион байгуулах зэргээр сургалт сурталчилгааг нэмэгдүүлсэн (дээрх өгүүллийг харна уу, үйл явц 5.2).

Казахстанд, NABU-ийн дэмжин хийсэн 15 минутын бөхөнгийн хүүхэлдэйн киног 2007 оны 10-р сард үзүүлсэн (бөхөнгийн мэдээ, дугаар 4, үйл явц 5.2). Бөхөнгийн судалгааны үр дүнг тусгасан зарим хэвлэл бий (БМ, дугаар 4, үйл явц 5.1).

Халимагт, бөхөн хамгаалал, бөхөнгийн тоо толгойн бууралтын учир шалтгааны талаар орон нутгийн хэвлэлд хэд хэдэн материал өгөөд байна (үйл явц 5.1), хүүхдийн гар зургийн уралдаан болсон (2007 оны 5 сар), Дефрагийн экологийн жижиг төсөл, Дарвины санаачлагын санхүүжилтээр БХХ-ны гишүүд сурталчилгааны материал тараагаад байна (үйл явц 5.2).

Олон улсад, 2007 оны 6-р сард БХХ шинэ веб сайт www.saiga-conservation.com гаргаж, “Бөхөнгийн мэдээ” сэтгүүлийн электрон шуудангийн жагсаалтыг өргөтгөх тал дээр ажиллаж байна (үйл явц 5.3, 5.4).

Бүлэг 6. Тархалтын зураг

Казахстаны Биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэг GIS-ийн мэргэжилтэн Степан Цукерийг Германы засгийн газраас санхүүжүүлж буй бөхөнгийн тархац, экологийн талаарх мэдээллийг нэгтгэх ажилд томилжээ (үйл ажиллагаа 6.1, 6.3).

Халимагт, ИНТАС-ийн санхүүжилтээр хийж буй “Степной санктuari”, “Чёрные земли” дархан газар дахь бөхөнгийн тархац, сүргийн хэмжээ, сүргийн бүтцийн талаарх компьютер мэдээллийн санг 2003 оноос хойш цуглуулж байна (үйл явц 6.1).

Монголд, 2006 оны 8-р сард Шинжлэх ухааны академи, ЗАХН хамтран бөхөн барьж сансрын дохиолол дамжуулагч хүзүүвч зүүсэн (БМ дугаар 4, үйл явц 6.2).

Бүлэг 7. Тусгай хамгаалалттай газар нутаг

Одоогоор энэ хэсэгт шинэ мэдээ байхгүй байна. Казахстанд Алтин-Дала хамгааллын төсөл идэвхитэй өрнөж бусад үйл ажиллагааг төлөвлөж байна (үйл явц 7.1).

Бүлэг 8. Урт хугацааны судалгаа

Казахстанд, 2007 оны 4-5-р сард бөхөнгийн 3 популяцийн агаарын тооллогыг хийсэн (үйл явц 8.1). Франкфуртын амьтан судлалын нийгэмлэгийн санхүүжилтээр ХАА, ойн нийгэмлэгийн хүсэвчлээр ирээдүйд хийх санал зөвлөмж бүхий агаарын мониторинг судалгааны үнэлгээг 2007 оны 4-р сард хараат бус зөвлөгч хийжээ (үйл явц 8.3).

Халимагт, бөхөнгийн үхэл хорогдол, төллөлт, сүргийн бүтэц, хэмжээ, тархац нутгийн мониторинг судалгааг өнгөрсөн жилүүдэд гүйцэтгэж үргэлжлүүлэн хийж байна (үйл явц 8.1, 8.2, 8.7, дээрх өгүүллийг хар).

Узбекистанд, онгоц ашиглах мониторинг хөтөлбөрийг боловсруулсан (дээрх өгүүллийг хар, үйл явц 8.6).

Монголд, 2007 оны 1-р сард бөхөнгийн тоо толгойн судалгаа хийж хамгийн багадаа 2000 орчим толгой бөхөн байгааг тогтоожээ (үйл явц 8.1).

Бүлэг 9. Үржүүлэх төв

Халимаг улсын зэрлэг амьтны төв нь өөрийн дадлага туршлагыг бусдад өвлүүлэн Орост үржүүлгийн төвийг шинээр байгуулжээ (Москвагийн амьтны хүрээлэн, Астрахан муж, Ростов). 2007 оны 5 сард “Степной санктuari” төвд хэд хэдэн төл хүлээн авсан бөгөөд эдгээр үржлийн төвд бөхөн үржүүлэх ажлыг нэмэгдүүлэх юм (үйл явц 9.3, 9.7).

Бүлэг 10-14. Популяцийн онцлогийн судалгаа

Баруун хойд Каспий: үйл ажиллагааны 10.2-10.4 (мониторинг, хамгаалал) үргэлжилж байна (БМ дугаар 4 болон дээрх өгүүллийг хар).

Урал: эдгээр үйл ажиллагааны талаар ямар нэг ахиц байхгүй.

Устюрт: ард иргэдтэй хамтарсан агаарын тооллогын төсөл Казахстан, Узбекистанд хэрэгжээд байгаа (12.4). Узбекистанд хууль хэрэгжилттэй холбоотой ажил (12.8) бий бөгөөд үүний үр дүнд дэд бүтэцтэй холбоотой гэрээ хийгээд байна (12.9).

Бетпак-дала: АСВР бөхөнгийн мэдээг харьцуулах үүрэг бүхий GIS-ийн мэргэжилтэнтэй болсон, Алтин-Дала хамгааллын төслийн төлөвлөгөөнийн хөтөлбөрт бөхөнгийн хамгааллыг бүрэн оруулаад байна (13.1). Хулгайн антай тэмцэх санхүүжилт үргэлжилж байна (13.2).

Монголд: үйл ажиллагааны 14.1, 14.5 дагуу байгууллагууд бага хэмжээний үйл ажиллагаагаа эхлээд байгаа хэдий ч мэдээлэл дутмаг хэвээр байна.

Тайлангийн зохион байгуулалт

Дунд хугацааны ажлын төлөвлөгөөний бүрэн хувилбар болон тайлантай холбоотой мэдээллийг http://www.cms.int/species/saiga/1st_saiga_range_states_meeting.htm хаягаар орж авна уу. Дээрх зүйлд ороогүй 2006 оны 9 сараас 2007 оны 6 сар хүртэлх хугацаанд хамаарах дунд хугацааны ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлтэй холбоотой шинэ үйл ажиллагаа байвал бидэнд илгээнэ үү. Бид дараагийн тайланд оруулах болно. Бидэнд мэдэгдээгүй ямар нэгэн үйл ажиллагаа болон энд мэдээлсэн үйл ажиллагааны талаар илүү мэдээлэл авахыг хүсвэл өөрийн улсад байх редакцийн зөвлөлийн гишүүн болон “Бөхөнгийн мэдээ” сэтгүүлийнхэнтэй холбогдоно уу.

Бөхөнгийн талаарх хэвлэлийн тойм

Орос хэл дээрх хэвлэл

Вознесенская В.В., Арылова Н.Ю., Арылов Ю.Н., Хлуднев А.В., Луцкеина А.А. 2007. “Хээрийн нөхцөлд бөхөнгийн ялгадас цуглуулах, бодисын солилцоо, дааврын агууламжид анализ хийх арга зүй”, Москва.

ИНТАС №03-51-3579 олон улсын төслийн гүйцэтгэлийн үр дүнд хээрийн нөхцөлд бөхөнгийн ялгадас цуглуулан анализ хийх арга зүйн лавлах орос хэл дээр хэвлэгдсэн. Энэхүү лавлах бичиг нь бөхөнгийн хамгаалал, үржлийн судалгаа хийж буй хөдөө хээр ажилладаг хэн бүхэнд хэрэгцээтэй зүйл мөн. Арга зүйн лавлах бичгийг rumsabcom@gmail.com хаягаар хандан электрон хэлбэрээр авах буюу хэвлэгдсэн хэлбэрийг шуудангаар авч болно.

Клеевзаль Ж.А. 2007. “Хөхтөн амьтдын насыг тодорхойлох арга зүй, дүрэм”, Москва: КМК Sci. Press.Ltd., 283 хуудас.

Та хамгийн энгийн, зохистой арга зүйг ашиглан амьтдын насыг нарийн тодорхойлох үндсэн арга зүйг мэдэх болно. Амьтдын наслалт, амьдралын талаар онцгой анхааран үзсэн байна. Номонд 100 гаруй хөхтөн амьтдын насыг тодорхойлох ялгаатай арга зүйг ашиглах өвөрмөц мэдээллийг оруулсан. Бөхөнгийн насыг тодорхойлох тусгай бүлэг энэ номонд багтжээ.

Холодова М.В. 2006. “Экосистемийн динамикийн судалгаанд ДНХ-ийн түүхэн болон орчин үеийн хэрэглээ”, Холоцен дахь орчин үеийн экосистемийн динамикийн судалгаа. Оросын шинжлэх ухааны хурлын бүтээл, Москва, 261-266 хуудас.

Зохиогчийн өгүүлснээр малтмалын цуглуулга нь экосистем болон популяцийн эволюцийн процессийг судлахад чухал нөлөөтэй юм байна. Хуучны арга зүйг ашиглан бөхөнгийн ДНХ-ийн үүслийг тодорхойлох боломжтой. Нарийвчлан үзэхийг хүсвэл http://www.sevin_ru/news/holo-cene-ecosystems-2006.pdf хаягаар хандана уу.

Бекенов А.В, Мелдебеков А.М, Грачев Ю.А. 2007. “Казахстан дахь бөхөнгийн хамгааллын төлөвлөгөө”, “Азийн тал хээрийн биологийн төрөл зүйл” олон улсын эрдэм шинжилгээний хурлын бүтээл. 2007 оны 4-р сарын 3-4. Казахстан, Костанай. 16-17 хуудас. Казахстаны бөхөнгийн одоогийн байдлын талаар судалгаа хийж популяцийн бууралтын шалтгааныг тодруулан бөхөн хамгааллын талаар санал зөвлөмж боловсруулжээ. Грачев Ю.А, Бекенов А.В нартай terio@nursat.kz хаягаар холбогдоно уу.

Грачев Ю.А. 2007. Казахстаны целөрхөг хээрийн экосистем дахь бөхөн. “Азийн тал хээрийн биологийн төрөл зүйл” олон улсын эрдэм шинжилгээний хурлын бүтээл. 2007 оны 4-р сарын 3-4. Казахстан, Костанай. 40-42 хуудас. Зохиогчийн өгүүлснээр өнгөрсөн үед ч одоо үед ч бөхөн задгай, хуурай нутагт байршдаг байна. Энэ зүйлд хамгийн тохиромжтой газар нутаг тус зүйлийн тархац нутаг дахь цөл, цөлөрхөг хээр, хээрийн бүс юм. Грачевтай terio@nursat.kz хаягаар холбогдоно уу.

Бөхөнгийн тархац нутгийн хэмжээнд цуглуулсан хамгааллын талаарх судалгаанд үндэслэн “Степной буллетин” (“Тал хээрийн мэдээ” товхимол)-д мэдээлэл хэвлүүлсэн. Энэ сэтгүүл нь олон улсын төслүүдийн талаарх мэдээлэл, тус зүйлийг хамгаалахад олон улсын оролцоо, харилцаа хамаарал ямар байгааг дурдсан байна. 2006 оны Казахстаны Алма-Атад болсон бөхөнгийн хамгаалал, зохистой хэрэглээний талаарх харилцан ойлголцлын гэрээний олон улсын анхны хурлын эмхтгэл хэвлэгдэн гарсан.

Милнер-Гүлланд Э.Ж, Луцкекина А.А, Бекенов А.Б, Арылов Ю.Н. “Бөхөн хамгааллыг ашиглан ард иргэдийн амьжиргааны түвшинг нэмэгдүүлэх нь” (хуудас 10-11).

Арылов Ю.Н, , Луцкекина А.А, Меджидов Р.А, Милнер-Гүлланд Э.Ж, Убушаев Б.С. “Халимаг дахь бөхөнгийн хамгаалал, судалгааны олон улсын төслүүд” (хуудас 11-14).

Грачев Ю.А, Бекенов А.В. “Казахстаны бөхөнгийн хамгаалал дахь хэтийн төлөв, хамгааллын байдал” (хуудас 15-17).

Быкова Е.А, Есипов А.В, Эпимов А.Ю, Головцов Д.Е. “Узбекистаны бөхөнгийн популяцийн одоогийн байдал, тоо толгойн бууралтын шалтгаан” (хуудас 17-20).

Маллон Д. Бөхөн олон улсад - сүүлийн 3 жилийн үйл ажиллагаа ба хэтийн төлөв (хуудас 20-22).

Маллон Д. Алматыгийн уулзгалт-бөхөн хамгааллын талаарх чухал алхмууд (хуудас 22-23)

“Каспий, түүний орчмын нутгийн биологийн төрөл зүйлийн зохистой хэрэглээ, хамгааллын асуудал” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээ-практикийн 5 дугаар хурлын бүтээл, 2006 оны 12-р сарын 7-8, Элиста, 204 хуудас.

Кокшунова Л.Е. “Байгаль дахь эр амьтны цөөхөн тохиолдолд Европын бөхөнгийн ороо” (хуудас 40-43).

Кокшунова Л.Е. “Холимог бүлгийн доторх 1 настай ооны зан төрх” (хуудас 43-45).

“Орос болон хил залгаа бүс нутгийн хөхтөн амьтан” сэдэвт олон улсын хурлын бүтээл. 2007 оны 1-р сарын 31-ээс 2-р сарын 2. Москва. 2007. 581 хуудас. Нилээд хэдэн өгүүллүүд бөхөн хамгааллын талаар дурдсан байна. Хураангуй хэлбэр удахгүй http://www.sevin.ru/menues1/index_rus.html хуудаснаа бэлэн болно.

Арылова Н.Ю, Луцкекина А.А, Вознесенская В.В. “Байгаль хамгааллын технологи болох бөхөнгийн нөхөн үржлийн статусын үл хамаарах мониторинг судалгаа” (хуудас 22).

Букреева О.М. “Баруун хойд Каспийн мужийн бөхөнгийн популяцийн байдал” (хуудас 61).

Есипов А.В, Быкова Е.А, Эпимов А.Ю, Головцов Д.Е. “2004-2006 оны тооллогын судалгаанд үндэслэсэн Узбекистаны Устюртын бөхөнгийн популяцийн байдал” (хуудас 148).

Ларионов К.О, Никонова О.А, “Бөхөн болон хонины тэжээлийн харьцуулалт” (хуудас 250).

Переладова О.Б, Лукаревский В.В, Мармазинская Н.В, Байдавлетов Р.Ж, Сидоренко Э.В, Украинский В.В, Грачев Ю.А. “Тууртан амьтдын сэргээн нутагшуулалт, хамгааллын тухай онцгой мэдээллийн ач холбогдол” (WWF-ийн 7 жилийн судалгааны ажлын үр дүн, хуудас 380).

Переладова О.Б. “Дархан цаазат газар болон газар ашиглалтын хөгжил дэвшлийн дүн шинжилгээнд зориулсан төв азийн тууртан амьтдын тархац, популяцийн талаарх судалгааны туршлага” (“Econet-Central Asia” төслийн судалгаанд үндэслэсэн, хуудас 381).

Сидоров С.В, Букреева О.М. “Баруун хойд Каспийн мужийн бөхөнгийн популяцийн байдал, өөрчлөлт, хэрэглээ” (хуудас 452).

Ангил хэл дээрх хэвлэл

Морган Е.Р, Мидлей Ж.П, Торгерсон П.Р, Шайкенов Б, Милнер-Гүлланд Э.Ж. 2007. “Казахстаны экологийн загвар бөхөнгийн популяцийн бууралтанд шимэгч амьтдын халдвар”.

Бөхөнгийн улирлын нүүдлийг хонины нүүдэлтэй холбон загвар зохиосон, ургамлын биомасс дээжийг цаг агаартай уялдуулан өвсөн дээр сул чөлөөтэй байх авгалдай амьдрал, нүүдлийг судалсан. Тус бүс нутагт хонь, бөхөнд элбэг байдаг Marshallagia, Naemonchus, Nematodirus хэмээх 3 чухал шимэгчийн амьдралын түүхийг загварт тусгаж чадсан нь бөхөн, хонины хоорондох халдварлалтын динамикийг урьдчилан тооцох боломжтой болжээ. Хонь, бөхөнгийн хоорондох шимэгчдийн зөвөрлөлт Marshallagia (хониноос бөхөн лүү өвлийн улиралд өмнө зүгт, бөхөнгөөс хонь луу зуны улиралд хойд зүгт тархана), Naemonchus (зуны улиралд хониноос бөхөн лүү хойд зүгт, намрын улиралд бөхөнгөөс хоньруу өмнө зүгт тархана) төрөлд хамгийн өндөр байгааг урьдчилан тогтсон байна. Бөхөнгийн Marshallagia төрлийн шимэгчийн халдвар өвлийн улиралд ямар байгааг харуулах загвараар тооцож үзэхэд өвлийн бэлчээрт очихоос өмнө бөхөнд энэ зүйлийн шимэгчийн дарамт бага байдаг байна. Зэрлэг амьтан мал хоорондын шимэгч зөвөрлөлтийг хянах цаашдын эпидемиологийн үндэс суурь тавигдах шаардлагатай загварын судалгаа харууллаа. Моргантай eric.morgan@bnstoj.ac.uk хаягаар холбогдоно уу.

Күүл А, Мистеруд А, Эрденов Ж.И, Луцкекина А.А, Грачев Ю.А, Бекенов А.Б, Милнер-Гүлланд Э.Ж. 2007. “Тал хээрийн “их өглөгч”: бөхөнгийн ихэрлэлт, эхийн бэлгийн онцлог”, “Royal Society”-ийн бүтээл, Б 274, 1293-1299 хуудас. Полигам хөхтөн амьтдын хувьд эм амьтнаа бодвол эр амьтны ач холбогдол өндөр байдаг. Гэсэн хэдий ч бэлгийн хувиарлалт хязгаарлагдмал дутагдалтай байдаг. Бид “хувиарлалтын шахалт” хэмээх таамаглал дэвшүүлж байна. Амьдрал түүхийг давтдаг шиг эхийн талын нөөц хувиарлалт нь өөр хүйсийн ихрээс илүү ижил хүйсийн ихэрт дамжих нөхцөл өндөр байдаг нь пренатал нөөцийн дутагдлаас шалтгаална. Полигам зүйлийн хувьд ихэр эр хүйсийн амьтан эхийн талаас дагалдагч нөлөөт зүйлсийг хүлээн авсан байдаг нь амьдрах хугацаа, нөхөн үржихүйн амжилтанд сөргөөр нөлөөлөх зүйл байж болзошгүй юм. Бид энэхүү таамаглалыг бөхөн дээр шалган үзлээ. Өндөр полигам зүйлийн хувьд эхийн талын нөлөө хамгийн өндөртэй нь тууртан амьтад байдаг. Энэхүү нөхөн төлжлийн өндөр түвшин нь эр амьтны оролцоог хязгаарлаж байна. Дөнгөж төрсөн болон хөврөлийн хөгжлийн сүүлийн шатанд байгаа янзаганы бэлгийн диморфизмийн түвшинг илэрхийлэн гаргалаа. Өмнө нь эр ихэр төрүүлсэн ихэрлэлтийн эр байх магадлал өмнө нь эм ихэр төрүүлсэн ихэрлэлтээс хэцүү байдаг нь ургийн чанар эсвэл давамгайлах байдлаас хамаарч болзошгүй. Полигам зүйлд эхийн давамгайлах бэлгийн онцлог нэмэгдэх тал дээр тодорхой анхаарах хэрэгтэй. Алайн Күүлтэй [aline.kuhl@imperial.ac.uk](mailto:kuhl@imperial.ac.uk) хаягаар холбоо барина уу.

Талархал:

Бидний үйл ажиллагааг дэмжин ажиллаж буй Патрика Нельсон, Сидней Бийрс Траст, Кеннон, Боб Худсон, Юди, Чек Вийтли, Линда Таборбек, Жон Гиббс нарт БХХ-ны зүгээс чин сэтгэлийн талархал дэвшүүлж байна.